



“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төсөл

Бодлого судлалын төвөөс хэрэгжүүлж буй “Малчдын байгууллага, төр-хувийн хэвшил-малчдын түншлэлийг бэхжүүлэх нь” гэрээт ажил

# УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ, МАЛЧДЫГ ЗАХ ЗЭЭЛТЭЙ ХОЛБОХ ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ - МАЛЧДЫН ТҮНШЛЭЛИЙН ЗАРЧМААР ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Улаанбаатар хот  
2023 оны 06-р сар

**Бодлого судлалын төв**

Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Соёл амралтын хүрээлэн, Жамъяан гүний гудамж 12 байр “Mongolian Properties”, 4-р давхар 4В, Улаанбаатар 14240

**Утас:** 77119027,

**e-mail:** [cpr@cpr.mn](mailto:cpr@cpr.mn)

**Web:** [www.cpr.mn](http://www.cpr.mn)

Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны хамтран хэрэгжүүлж буй “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийн дэмжлэгээр бүтээв. Тус бүтээлийн агуулгад санхүүжүүлэгч болон хэрэгжүүлэгч байгууллагуудын албан ёсны бодлого, байр суурийг илэрхийлээгүй болно.

**Боловсруулсан:** Бодлого судлалын төвийн баг

**Хэвлэлийн хуудас:** 5.0 х.х

**Цаасны хэмжээ:** 70x100/16

Бест Колор Интернэшнл ХХК-д эхийг бэлтгэж, хэвлэв.

# АГУУЛГА

1	МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ “АДАПТ” ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА .....	5
2	“АДАПТ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГА, ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЛААР .....	8
3	ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СҮМД СОНГОСОН ТАЛААР .....	18
4	УУР АМЬСГАЛД ТЭСВЭРТЭЙ ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛИЙН ЗАРЧМААР ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ .....	22
4.1	Бэлчээр ашиглалтын гэрээ, урамшууллын механизм .....	23
4.2	Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг тогтоох .....	31
4.3	Хурга махлуулж өсвөр насны малыг эдийн засгийн эргэлтэд оруулах .....	35
4.4	Малыг нэг цэгт төвлөрүүлж, хоршоогоор дамжуулан худалдан борлуулах ..	41
4.5	Ноолуурыг нэг цэгт цуглуулж, хоршоогоор дамжуулан худалдан борлуулах .....	45
4.6	Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан чиглэл нэг бүрээр сумын төсвөөс санхүүжүүлэх боломжтой загвар үйл ажиллагааны санал .....	48
5.	ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРОЛЦОГЧИДТОЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ .....	51
5.1	Ноолуур бэлтгэлийн чиглэлээр байгуулах санамж бичиг .....	51
5.2	ХАА-н биржтэй байгуулах санамж бичиг .....	55
5.3	Мал эмнэлгийн ерөнхий газартай байгуулах санамж бичиг .....	59
5.4	Аймгийн мал эмнэлгийн газартай байгуулах санамж бичиг .....	63
5.5	Аймгийн ХХААГ-тай байгуулах санамж бичиг .....	66
5.6	Сумын засаг даргатай байгуулах санамж бичиг .....	69
5.7	Махны холбоотой байгуулах санамж бичиг .....	73
5.8	Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоотой байгуулах санамж бичиг .....	78
	<b>Хавсралт 1.</b> Загвар үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх талаар сумдаас ирүүлсэн албан тоот .....	82
	<b>Хавсралт 2.</b> Хөрөнгө оруулалтын анх дугаар үзэсгэлэнгийн хөтөлбөр .....	98

## ТОВЧИЛСОН ҮГС


АДАПТ	“Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” төсөл
АХБ	Азийн хөгжлийн банк
БАГ	Бэлчээр ашиглалтын гэрээ
БИНХ	Багийн иргэдийн нийтийн хурал
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОХУБ	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
БСТ	Бодлого судлалын төв
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
МАА	Мал аж ахуй
МННХ	Монголын ноос, ноолуурын холбоо
МХААХҮХ	Монголын Хөдөө Аж Ахуйн Хоршоологчдын Үндэсний холбоо
МЭАЦТЛ	Мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
МЭНС	Мал эмнэлгийн нэгдсэн систем
МЭҮН	Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж
МЭТ	Мал эмнэлгийн тасаг
МЭХ	Мал эмнэлгийн холбоо
НҮБХХ	Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТХХМТ	Төр-хувийн хэвшил- малчдын түншлэл
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
УАӨ	Уур амьсгалын өөрчлөлт
УАТХ	Уур амьсгалд тэсвэртэй хөгжил
ХАА	Хөдөө аж ахуй
ХАА-н бирж	Хөдөө аж ахуйн бирж
ХААТ	Хөдөө аж ахуйн тасаг
ХМЭХ	Хувийн мал эмнэлгүүдийн холбоо
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЭСҮТ	Экосистемийн үйлчилгээний төлбөр

# НЭГ. “МОНГОЛ ОРНЫ ХӨДӨӨГИЙН ИРГЭДИЙН УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТӨД ДАСАН ЗОХИЦОХ ЧАДАМЖ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ НЬ” (АДАПТ) ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## ТӨСЛИЙН ТОВЧООН

### ЗОРИЛГО:

Байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх



**Хэрэгжих хугацаа:**  
2021-2028 он



**Санхүүжүүлэгч байгууллага:**  
Уур амьсгалын ногоон сан



**Хэрэгжүүлэгч талууд:**  
БОАЖЯ, ХХААХҮЯ, НҮБХХ

**Хэрэгжих газар:**  
Дорнод, Сүхбаатар, Завхан,  
Ховд аймгийн 68 сум



**Оролцогч талууд:**  
Төслийн зорилтот аймаг,  
сумын Засаг даргын тамгын  
газар, бусад холбогдох  
төр, төрийн бус, хувийн  
хэвшлийн байгууллагууд,  
байгалийн нөөцийн хамтын  
менежментийн  
байгууллагууд, малчид

### Төсөл хэрэгжих үндэслэл:

Сүүлийн 70 жилд Монгол орны хэмжээнд агаарын температур  $2.25^{\circ}\text{C}$ -аар нэмэгдсэн нь Монгол орныг уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн их өртөж буй улс орны тоонд оруулж байна. Агаарын температур нэмэгдэхийн зэрэгцээ хур тунадасны хэмжээ буурсан нь цөлжилт, хуурайшилтыг нэмэгдүүлж, бэлчээр, усны нөөцийг багасган, байгалийн бүс бүслүүр шилжихэд хүргэж байна.

Түүнээс гадна зуд турхан ган гачиг, их цас унах, шар усны үер буух болон хэт халж, хэт хүйтрэх зэргээс учрах гамшигт үзэгдлийн давтамж, эрчим нэмэгдэж байна. Жилийн дөрвөн улиралд байгалийн нөхцөлөөс шууд хамааралтай байдаг малчдын зүгээс уур амьсгалын нөлөөлөлд хэрхэн дасан зохицох, хариу үйлдэл, нөлөөлөх талаар зохих мэдлэг, мэдээлэлгүйгээр зохион байгуулагдаж ирсэн.

Мал маллагааны арга ажиллагаа, малын тоо толгой зохисгүй хэмжээнд байгаа нь улам бүр эмзэгшиж буй экосистем, экосистемийн үйлчилгээнд давхар нэрмээс болж байна.

### **Төслийн ерөнхий танилцуулга:**

Уур амьсгалын Ногоон сангийн санхүүжилтээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам хамтран “Монгол орны хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж болон эрсдэлийн менежментийг боловсронгуй болгох нь” (АДАПТ) төслийг 2021-2028 он хүртэл буюу 7 жилийн хугацаанд Ховд, Завхан, Дорнод, Сүхбаатар аймгуудын 68 суманд хэрэгжүүлнэ.



**Төсөл нь байгалийн нөөцөөс хамааралтай хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамжийг дээшлүүлэх зорилгоор дараах бүрэлдэхүүн хэсгүүдийн хүрээнд үйл ажиллагааг хэрэгжүүлж байна. Үүнд:**

1. Үндэсний болон бүс нутгийн түвшинд газар, усны ашиглалтыг уур амьсгалын мэдээлэлд тулгуурлан төлөвлөж, хэрэглэдэг болох
2. Уур амьсгалын өөрчлөлтөд зохицсон ус, хөрсний менежментийн арга ажиллагааг өргөн хүрээнд нэвтрүүлэн, байгалийн нөөцийн менежментэд малчдын оролцоог нэмэгдүүлэх
3. Гарал үүсэл нь тогтвортой, уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, малчдын байгууллагын чадавхыг нэмэгдүүлж, бэхжүүлэх

**Төсөл хэрэгжсэнээр уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг иргэд, орон нутаг, бүс нутгийн өртөмтгий байдал багасч, даван туулах чадвар нэмэгдсэн байна.**

- Ойролцоогоор 130.000 малчин иргэн шууд, 800,000 иргэн шууд бусаар төслийн үр шим хүртэхээс 50 хувь нь эмэгтэйчүүд байна.
- Аймаг, сумын хөгжлийн төлөвлөлтийг бэлчээрийн даац, уур амьсгалын өөрчлөлтийн мэдээлэлд үндэслэн гаргах, гол мөрний сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг шинэчлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.
- Малчид уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй мал сүрэгтэй болох, гарал үүсэл нь тогтвортой чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, зах зээлд харьцангуй өндөр үнэтэй нийлүүлэх боломжийг бүрдүүлнэ.

**Экосистемийн даац, үйлчилгээ сайжирсан байна.**

**Уур амьсгалын мэдээлэлд түшиглэсэн төлөвлөлтийг дэмжсэн институцийн болон зохицуулалтын тогтолцоо бэхэжсэн байна.**

- Уур амьсгалын мэдээлэл боловсруулж, ашиглан шийдвэр гаргах байдал сайжирсан байна.
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадамж сайжирч, өртөх эрсдэл буурсан байна.

**Малчид, малчдын байгууллагуудын оролцоо, хүлээгдэж буй үр дүн**

Төслийн зүгээс малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэхэд төр-хувийн хэвшил-малчдын хамтын ажиллагааг дэмжих, бүтээгдэхүүнд үнэ цэн шингээх, үндэсний болон олон улсын стандарт шаардлагад нийцүүлэх, брэнд бүтээгдэхүүн, үйл ажиллагаа бий болгох, хөдөөд ажлын байр нэмэгдүүлэх, мал аж ахуйн болон малчдын усан хангамжийг нэмэгдүүлэх, өвс, хадлан тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх үндсэн зорилготойгоор үйл ажиллагаагаа төлөвлөн хэрэгжүүлж байна.

# **ХОЁР. “АДАПТ” ТӨСЛИЙН ХҮРЭЭНД БОДЛОГО СУДЛАЛЫН ТӨВӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БАЙГАА “МАЛЧДЫН БАЙГУУЛЛАГА, ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛИЙГ БЭХЖҮҮЛЭХ НЬ” ГЭРЭЭТ АЖЛЫН ТАЛААР**

**Гэрээт ажлын хугацаа:** 2023 оны 5-р сараас 2025 оны 2-р сар

## **Гэрээт ажлын зорилго:**

Төр-хувийн хэвшил- малчдын түншлэл (ТХХМТ)-н зарчмыг нэвтрүүлж, сайжруулах, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлд нэвтрэх чадавхыг нэмэгдүүлэх, нэмүү өртөг шингэсэн МАА-н бүтээгдэхүүний талаар малчдын байгууллага/бүлэг, хоршоо/-г бэхжүүлэх явдал юм. Урт хугацаанд тогтвортой ажиллах ТХХМТ-н зарчмыг төлөвшүүлэх нь тогтвортой, уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн бүтээгдэхүүнийг хөгжүүлэхэд амин чухал юм.

## **Гэрээт ажлаас гаргах үр дүн:**

- ТХХМТ-н боломжуудыг илрүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх хөрөнгө оруулалтын үзэсгэлэн зохион байгуулж, сурталчлах
- Малчдын бүлэг, хоршоог бэхжүүлэх эрх зүй, зохицуулалтын таатай орчин, боломжит хөшүүргүүдийг тодорхойлж, түрших
- Төсөл хэрэгжиж буй 4 аймагт уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн дадлыг сурталчлах, дэлгэрүүлэх үүднээс хувийн хэвшлийн зүгээс хөрөнгө оруулах боломжийг тодорхойлж, түрших
- Уур амьсгалд тэсвэртэй мал аж ахуйн дадлыг сурталчлахад төр, хувийн хэвшил, малчдын байгууллагад мэргэжлийн дэмжлэг үзүүлэх юм.

## **Гэрээт ажлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлүүд:**

- 4 аймгийн эрсдэлтэй бүс нутагт малчдын бүлэг хоршооны эмзэг бүлгийн гишүүдийг дэмжих зорилтот хөтөлбөр боловсруулах, ТХХМТ-н хүрээнд хамтран ажиллах загварыг боловсруулж нэвтрүүлэх
- УАӨ-д дасан зохицсон ухаалаг МАА-н үйлдвэрлэлийн зах зээлийн шинжилгээ (эрэлт, нийлүүлэлт) хийж, хөрөнгө оруулалтын үзэсгэлэн зохион байгуулах
- УАӨ-д дасан зохицсон ухаалаг МАА-н дадлыг өртгийн сүлжээнд түрших, МАА-н бүтээгдэхүүний хэрэглэгчдэд батлан харуулах



- УАӨ-д дасан зохицсон МАА-н үйлдвэрлэлийг дэмжихэд нь төр, хувийн хэвшил, малчдын бүлэг, хоршоодод бодлогын зөвлөмж өгөх /дор хаяж 4 загварыг боловсруулж, туршсан байх/

### **Гэрээт ажлыг хэрэгжүүлэх зохион байгуулалт:**

Гэрээт ажлаар эхний ээлжид төслийн 4 аймгаас 8 сум сонгож, уур амьсгалд тэсвэртэй загвар үйл ажиллагааг төр-хувийн хэвшил-малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар 2023 оны 6-р сараас 2024 оны 6-р сарын хугацаанд туршина. Энэхүү туршилтын үр дүнг үндэслэн загвар үйл ажиллагааг 4 аймгийн бусад сумдад нэвтрүүлэх үүднээс сурталчлах, чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг 2024 оны 7-р сараас 2025 оны 2-р сарын хугацаанд хэрэгжүүлэх юм.

### **Гэрээт ажлын хүрээнд хэрэглэгдэж буй гол ойлголтуудын талаар**

#### **Уур амьсгалд тэсвэртэй хөгжил**

Уур амьсгалд тэсвэртэй хөгжил /УАТХ/ гэдэг нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар тогтвортой хөгжилд хүрэх үйл явц юм.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод:

- Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмэр оруулна /Зорилт 6.4/
- Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, тэсвэрлэх чадавхыг бэхжүүлж, үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулна / Зорилт 6.4, I үе шатны 3 дахь зорилт/ гэж заажээ.

УАТХ-н зорилтыг хангахад нийт хүлэмжийн хийн тал гаруй хувийг ялгаруулдаг ХАА-н салбар онцгой үүрэгтэй.

“Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод:

- Хөдөө аж ахуйг байгальд ээлтэй, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, эрсдэл даах чадвартай, нийгмийн хөгжлийн чиг хандлага, хэрэгцээ, шаардлагад нийцсэн, хариуцлагатай, бүтээмж өндөр, тогтвортой үйлдвэрлэлтэй эдийн засгийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлнэ / Зорилт 8.3./
- Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжинэ / I үе шат, 2021-2030/ гэж заасан.

Уур амьсгалд тэсвэртэй хөгжил нь гол гогцоо асуудлаа тодорхойлох, боломжит шийдлүүдийг илрүүлж, үнэлэх, зөв шийдлээ хэрэгжүүлэх, хэрэгжилтэд мониторинг хийж, урагшлах гэсэн үйл явцаар дамжин хэрэгждэг (Зураг 1).

Байгаль, нийгмийн олон хүчин зүйлээс хамаардаг энэхүү үйл явцын эцсийн үр дүн нь оролцогч талуудын хамтын ажиллагаа, шаардагдах хөрөнгө оруулалтын хэмжээнээс шууд хамаардаг.

АДАПТ төслөөс уур амьсгалд тэсвэртэй, тогтвортой хөгжлийн шалгуур хангасан МАА-н бүтээгдэхүүнийг дэмжих, зах зээлтэй холбох зорилт дэвшүүлсэн юм.

Төслийн 4 аймгаас 8 сум сонгож, уур амьсгалд тэсвэртэй загвар үйл ажиллагааг төр-хувийн хэвшил-малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар туршиж хэрэгжүүлэхээр төслийн гэрээт байгууллага Бодлого судлалын төв ажиллаж байна.



### *Уур амьсгалд тэсвэртэй хөгжлийн үйл явц*

Нэр бүхий сумдад туршиж, үр дүн нь тодорхой бөгөөд мөшгөн баталгаажуулах боломжтой загвар үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшил, бусад эх үүсвэрээс татах үзэсгэлэнг дараах чиглэлээр зохион байгуулах саналтай байна.

## Хөрөнгө оруулалтын үзэсгэлэнгийн талаар

Өргөн утгаараа хөрөнгө оруулалт гэдэг нь ашиг олох, давуу тал бий болгох зорилгоор аливаа зүйлд зарцуулсан мөнгө, хүч хөдөлмөр, цаг хугацаа юм.

Өөрөөр хэлбэл хөрөнгө оруулалтыг санхүүгийн салбарт ашигладаг үндсэн хөрөнгийг нэмэгдүүлэх зардал гэж явцуу утгаар нь ойлгохгүй гэсэн үг.

МАА-н салбарт санхүүгийн явцуу утгаар хөрөнгө оруулалт бага хийгддэг нь эрсдэл өндөр, улирлын чанартай, барьцааны чанар муу гэх мэт олон шалтгаантай. Иймд өвс, тэжээл, малын эм тарилга, тээвэр, түлш зэрэг үндсэн хөрөнгө биш харин эргэлтийн хөрөнгө буюу урсгал зардалд оруулах хөрөнгө оруулалт харьцангуй их байдаг. Мөн төсвөөс оруулах хөрөнгө оруулалтын хувьд худаг гаргах гэх мэт үндсэн хөрөнгө оруулалтын зардлаас гадна тэжээлийн нөөц бүрдүүлэх зэрэг эргэлтийн хөрөнгөд зарцуулдаг гадна эко системийн үйлчилгээний төлбөр буюу мал борлуулсны урамшуулал олгож малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх зорилтыг хангаснаар уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-өд дасан зохицох чадавхыг нэмэгдүүлж, биологийн олон янз байдлыг хамгаалах гээд олон давуу тал үүсдэг, энэ нь хөрөнгө оруулалтын нэн чухал чиглэл юм.

Ийнхүү хөрөнгө оруулалтыг ТХХМТ-д оролцогч төр, хувийн хэвшил, малчдын зүгээс оруулах боломжтой бүхий л боломж, хэлбэрээр татах зорилт тавьж байна.

## Анхдугаар үзэсгэлэн

Анхдугаар үзэсгэлэнг Бодлого судлалын төв /БСТ/-өөс 2023-2024 онд хэрэгжүүлэх “Малчдын байгууллага, төр-хувийн хэвшил-малчдын түншлэлийг бэхжүүлэх нь” гэрээт ажлыг оролцогч аймаг, сумдын хувьд албан ёсоор эхлүүлэх, тэдний зүгээс болон төр, хувийн хэвшлийн бусад оролцогчдын зүгээс хөрөнгө оруулалт татах эхний үзэсгэлэнг хамтатган энэ 6-р сарын 21-ний өдөр зохион байгуулсан болно. Хөтөлбөрийг Хавсралт 2-д үзүүлэв.

Оролцогчид нь 4 аймгийн Засаг дарга, аймгийн ХХААГ-н дарга, МЭГ-н дарга, 8 сумын Засаг дарга, мөн сум бүрээс нэг нэг хүн /малчид, хоршоо, МЭТ, МЭҮН зэргийн төлөөлөл/ зэрэг 28 хүн, НҮБХХ, БОАЖЯ, ХХААХҮЯ, МЭЭГ, ХАА-н бирж, АДАПТ төсөл хэрэгжүүлэх нэгж, БСТ болон хоршоо, боловсруулах үйлдвэр зэрэг хувийн хэвшлийн төлөөллийг багтаасан 30, нийт 60 орчим хүн байна.

Үзэсгэлэнгээр танилцуулж, сурталчлах гол загвар нь оролцогч 8 сумын Засаг дарга төсвөөсөө мөнгө гаргаж хэрэгжүүлье хэмээн хүлээн зөвшөөрсөн УАТХ-ийн загвар үйл ажиллагааны цогц байх юм. Үүнд:

1. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээ
2. Малаа борлуулж, цөөлөхөд нь урамшуулах эко системийн үйлчилгээний төлбөр
3. Мал, бүтээгдэхүүний чанар, борлуулалтыг дэмжих хурга махлуулах, малчны ногоон зээл, малчдын бүлгийн халдварт өвчнөөс эрүүл нутаг, түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт зэрэг орлого өсгөх боломжийг тэтгэх хөшүүргүүд
4. Төсвийн хуулийн 60.2.8-д заасан малын тоо толгойн албан татвараас санхүүжин сумдад хэрэгжүүлэх боломжтой 11 чиглэлийн УАТХ -н загвар үйл ажиллагаанууд

#### **Үзэсгэлэнгийн гол зорилго нь:**

1. Дээрх загвар үйл ажиллагааг үндэсний түвшний шийдвэр гаргагчид болон оролцогч аймгийн удирдлагад ойлгуулах замаар тэдний зүгээс бодлогын болон санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх амлалт /commitment/ гаргуулах
2. Оролцогч сумдын зүгээс урьд дэмжсэн байр сууриа тодруулж, бодлогын болон төсвийн ямар дэмжлэг үзүүлэхээ илэрхийлэх, төслийг хэрхэн хэрэгжүүлж, бодитой үр дүн гаргах талаар санал бодлоо хуваалцах юм.

Үзэсгэлэнгийн үеэр загвар үйл ажиллагааг ТХХМТ-н зарчмаар хамтран хэрэгжүүлэх, үүнд тодорхой хөрөнгө гаргах үүрэг амлалт бүхий санамж бичгийг оролцогч талуудтай байгуулж байна.

#### **Төр-хувийн хэвшлийн түншлэл гэж юу вэ?**

Төр, хувийн хэвшлийн түншлэл /ТХХТ/ нь төрийн болон хувийн хэвшлийн оролцогчдын урт хугацаанд тогтвортой хамтран ажиллах загвар бөгөөд энэхүү хамтын ажиллагаа нь гэрээ, санамж бичиг зэрэг албан бичиг баримтаар баталгаажсан бол илүү гэж үздэг.

Хамтран ажиллах үндэслэл нь хамтран ажилласнаар ТХХТ-ийн хүрээнд тавьсан зорилгоо хэрэгжүүлэхэд тус тусдаа ажилласнаас илүү үр дүнтэй байдагт оршдог байна. Өөрөөр хэлбэл оролцогч талууд харилцан бие биеэ дэмжиж, дутуугаа нөхөх зарчмаар ажилладаг байна.

ТХХТ-н давуу тал нь дараах зүйлд оршдог. Үүнд:

- Хувийн хэвшилтэй хамтран ажилласнаар төр бусад тохиолдолд ашиглах боломжгүй технологи, мэдлэг, арга барилыг ашиглах боломжтой болдог
- Хувийн хэвшилтэй хамтран ажилласнаар төслийн тогтвортой байдал, үр ашиг нэмэгддэг
- Хөгжиж буй орнууд олон улсын зах зээлд нэвтрэх боломжийг түлхүү олгодог
- Хувийн хэвшилд итгэх олон нийтийн итгэлийг сэргээж, нэр хүнд нь дээшилдэг
- Хувийн хэвшлийнхэн хөгжлийн төсөл, хөтөлбөрийн хүрээн дахь шинэ мэдлэг, туршлагыг хуваалцах боломжтой болдог байна

### Төр-хувийн хэвшил- малчдын түншлэл /ТХХМТ/ гэж юу вэ?

ТХХМТ нь төр-хувийн хэвшлийн түншлэлийн шинэлэг хэлбэр бөгөөд хувийн хэвшлийн зүгээс зөвхөн ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэхэд анхаарах бус орон нутаг, нутгийн иргэдийн хөгжилд анхаарлаа хандуулах шаардлагаас үүдэн гарсан байна. ТХХМТ-н нөхцөлд нутгийн иргэд, төр, захиргааны байгууллага аливаа төсөлд төлөвлөхөөс нь эхлээд хэрэгжүүлэх, мониторинг хийх бүх шатанд оролцож, орон нутгийн “өмчлөл”, оролцоо, хүртэх өгөөжийг нэмэгдүүлдэг байна. ТХХМТ-н зарчмыг нэвтрүүлснээр аливаа төсөл, санаачилгыг хэрэгжүүлэхэд:

- Хувийн хэвшил нь үйлдвэрлэгчид, бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн тэнцвэртэй оролцоог хангаж, урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар
- Төр нь нэмэлт хөрөнгө оруулалт татаж, оролцогчдын сонирхол, “өмчлөлийг” хангаснаар
- Орон нутгийн иргэд /community/ нь шинэ мэдлэг, ур чадвар, технологи эзэмшсэнээр тус тус ашиг хүртдэг байна.

Дээрх үзэл баримтлал, зарчмыг үндэслэн ТХХМТ-н зарчмыг дараах асуудлуудыг шийдвэрлэхэд ашиглах боломжтой. Үүнд:

1. Мал, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэг цэгт төвлөрүүлэн чанарын хянан баталгаа хийлгэж, боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах зөвлөмжид хувийн хэвшлийг төлөөлүүлэн боловсруулах үйлдвэр,

мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, нутгийн захиргааг төлөөлүүлэн сумын хөдөө аж ахуйн тасаг, мал эмнэлгийн тасаг, нутгийн иргэдийг төлөөлүүлэн малчдыг оролцуулснаар:

- i. Бүтээгдэхүүнийх нь үнэлэмжийг нэмэгдүүлж, тээврийн зардлыг хэмнэх замаар малчдын орлогоо нэмэгдүүлэх сонирхлыг хангах
  - ii. Чанарын баталгаатай түүхий эдийг ченжээр дамжуулалгүй зардал чирэгдэл багатай худалдан авснаар эцсийн бүтээгдэхүүний чанар, үнийг өсгөн урт хугацаанд тогтвортой өндөр ашиг олох хувийн хэвшлийн сонирхлыг хангах
  - iii. Түүхий эдийн чанарыг нүдээр үзэж, шаардлагын түвшинд баталгаажуулснаар хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарын стандартыг хангуулах төрийн сонирхлыг хангах боломжийг нэмэгдүүлэх
2. Экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/-г мал борлуулсны урамшуулал хэлбэрээр олгож орон нутгийн захиргаа, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, иргэд, малчдын оролцоо, сонирхлыг хангах замаар малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх замаар мал аж ахуйг тогтвортой хөгжлийг хангах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох орон нутгийн чадавхыг дээшлүүлэх, биологийн олон янз байдлыг хамгаалах нийтлэг зорилтыг хангахад ашиглах
3. Хурга махлуулж борлуулах ажлын хүрээнд мах боловсруулах үйлдвэр, хэрэглэгчид, тэжээл үйлдвэрлэгчид, мах үйлдвэрлэгч малчид болон хүнсний аюулгүй байдал, чанарын стандартыг хариуцсан төрийн байгууллагын сонирхлыг хослуулан хэрэгжүүлэх
4. Аймаг, сумын мал эмнэлгийн байгууллага, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, малчдын оролцоотойгоор бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлэг, нөхөрлөлийн гэрээт бэлчээрийг халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох зөвлөмжийг хэрэгжүүлснээр нэг талаас малчдын бүтээгдэхүүний үнэлэмж, орлогыг нэмэгдүүлэх, экспортын гарцыг сайжруулах, нөгөө талаас эрүүл хүнс хэрэглэх хэрэглэгчдийн болон нийтийн эрх ашгийг хангах зорилтыг цогцоор нь шийдэх

### **Малчдын үйлдвэрлэлийн байгууллагын талаар**

Манай орны бэлчээрийн мал аж ахуйн нөхцөлд МАА-н үйлдвэрлэлийн

үндсэн нэгж нь малчин өрх, хот айл юм. Өөрөөр хэлбэл МАА-н үйлдвэрлэлийн үндсэн хэрэгсэл болсон малыг өмчлөгч нь малчин өрх бөгөөд малыг өмчлөх, борлуулах, хүнсэнд хэрэглэх зэргээр захиран зарцуулах шийдвэр гаргагч нь өрх юм.

Малын хариулга, маллагаа, бэлчээр, ус ашиглалт, тэжээл, мал эмнэлэг гэх мэт орц, үйлчилгээ худалдан авах зэрэг үйлдвэрлэлийн хүрээний зарим чухал асуудлуудыг мал нь цугтаа хотолж, бэлчдэг хот айлын хүрээнд шийдвэрлэж байна. Иймд малчдын үйлдвэрлэлийн байгууллага, түүнийг бэхжүүлэх гэдэг ойлголт нь малчин өрх, хот айлын зохион байгуулалтын хүрээнд шийдвэрлэгдэх бөгөөд өөр ямар нэгэн байгууллагын талаар ярих боломж хязгаарлагдмал юм. Малчдын бүлэг, нөхөрлөл нь бэлчээр, ус зэрэг байгалийн нөөцийг ашиглах хүрээнд албан бусаар хамтран ажиллах хүрээнд бий болдог бөгөөд цаашид бэхжүүлж, албан гэрээ хийсэн нөхцөлд бэлчээр, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хамгаалах чиг үүрэг бүхий хариуцлагатай нэгж болоод явах бүрэн боломжтой, гэхдээ МАА-н үйлдвэрлэлийн нэгж биш юм.

Харин өртгийн сүлжээнд үйлдвэрлэлийн дараагийн шат болох бүтээгдэхүүнийг цуглуулах, тээвэрлэх, хадгалах, анхан шатны тордолт, боловсруулалт хийх, борлуулах шатанд зохион байгуулалтын үндсэн нэгж нь олонх оронд үйлчилгээний хоршоо байна. Манай оронд өртгийн сүлжээний дээрх чиг үүргүүдийг хоршоогоор гүйцэтгүүлэх зорилт дэвшүүлж, хоршоог дэмжих талаар олон арга, олон тооны бодлого, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсэн ч шаардлагын түвшинд хүртэл хөгжиж, “ченжийг” орлох хэмжээнд хүрч чадахгүй байна. ХХААХҮЯ-ны Хяналт, үнэлгээний газраас 2020 онд явуулсан үнэлгээгээр хоршоодын олонх нь хоршооны тухай хууль болон холбогдох зарчмын дагуу байгуулагдаагүй болох нь тогтоогджээ. Хоршоод нь гишүүдийн өмчлөлийн байгууллага бус харин цөөн хувь хүний мэдлийн байгууллага болсон байна. Төслийн хүрээнд малчдын бүлэг, нөхөрлөл, үйлчилгээний хоршоог цогцоор нь хөгжүүлэх доорх загварыг туршин хэрэгжүүлэх боломжтой юм.

**Малчдын бүлэг, хоршоог цогцоор бэхжүүлэх загвар**



Албан бус бүлэг    Бүртгэлтэй албан бүлэг    **Хуулийн этгээд эрхтэй** байгууллага /хоршоо болж, гишүүдэдэ давуу талыг ойлгуулж, ашиг хүртээх

**Хуулийн этгээд бүс**

***Малчдын бүлэг, хоршоог цогцоор нь бэхжүүлэх загвар, үе шатаар***

Өөрсдөд нь ямар ашигтайг ойлгуулах замаар сайн дураар оролцох боломжийг олгохын төсөлд хамрагдаж байгаа сумын бүх малчин өрхийг нүүр тулсан сургалтад хамруулахаас үйл ажиллагаа эхэлнэ.

Дараагийн шатанд, гэрээгээр ашиглуулах бэлчээрийн хил заагийг тогтоон даацыг тодорхойлж, бүртгэсний үндсэн дээр сонгогдсон малчдын бүлэгтэй сумын Засаг дарга бэлчээр ашиглалтын гэрээ байгуулна. Гэрээ нь ашиглах бэлчээрийн хил заагийг албан ёсоор хүлээн зөвшөөрч хил заагийн хүрээнд бэлчээрийн даац, талхагдлыг тооцсон бодитой мэдээллийг гаргаж, түүнийг бууруулах хариуцлагын хөшүүргийг нэвтрүүлэх замаар малын тооноос чанарт шилжих сэтгэлгээг төлөвшүүлэх юм. Бүлгийн гэрээ байхгүй, ашиглалтын хил зааг тодорхойгүй буюу бэлчээрийг нийтээр дундаа ашиглаж байгаа одоогийн нөхцөлд энэ нь ямар ч боломжгүй юм.

Дараагийн шат нь аль болох олон мал аж ахуйн эргэлтэд оруулан борлуулах замаар малынхаа тоог бэлчээрийн даацад нийцүүлэх, малчдын мөнгөн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэнэ. Албан бус чөнжүүдээр дамжуулан борлуулж байгаа нөхцөлд малчдын тухайд хэлэлцэх, зөвшилцөх, нэгдсэн шийдэлд хүрэх чадавх сул байдаг дутагдлыг шийдвэрлэх зорилгоор албан ёсны хуулийн этгээдийн эрхтэй зохион байгуулалтыг түрших юм. Түршилтын хүрээнд чанартай бүтээгдэхүүнээ үнэд хүргэхийн тулд төрийн бус байгууллага, хоршоогоор дамжуулан боловсруулагч нартай шууд



гэрээ байгуулан борлуулах ажлыг зохион байгуулна. Давуу, сул талыг нь харьцуулан таниулах сургалтын үр дүнд малчид хуулийн этгээдийн статустай албан ёсны байгууллагыг төрийн бус байгууллага, хоршоо гэсэн хоёр боломжит хувилбараас сонгоно.

Санал болгож буй загвар нь малчид/үйлдвэрлэгчид, боловсруулагчид/ худалдан авагчид болон орон нутгийн засаг захиргаа зэрэг гол оролцогч талуудад аль алинд нь ашигтай “ялагч-ялагч” шийдлийг санал болгож, малын гаралтай бүтээгдэхүүний борлуулалтыг тогтвортой зохион байгуулах чадвартай малчдын байгууллагыг бий болгох боломжийг турших юм. Төрийн бус байгууллагын хувилбарыг үйлчилгээний жинхэнэ хоршоог байгуулах эрх зүйн орчин бүрдэх хүртэл шилжилтийн үе шат хэмээн үзэж байгаа болно.

## **ГУРАВ. ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХЭРЭГЖҮҮЛЭХ СУМД СОНГОСОН ТАЛААР**

Доор дурдсан чиглэлээр загвар үйл ажиллагааг хамтран хэрэгжүүлэх сонирхлоо ирүүлэхийг урьсан албан тоотыг 4 аймгийн нийт сумдад явуулж, эдгээр загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх шалгууруудыг бүрэн зөвшөөрч, хамтран хэрэгжүүлэхээ илэрхийлж, сумын Засаг даргаас ирүүлсэн албан тоот, ХАА-н түүхий эдийг борлуулахад гол нөлөөлдөг дэд бүтэц /хатуу хучилт зам/, бүлэг, хоршооны хөгжлийн түвшин зэрэг үзүүлэлтийг үндэслэн сумдыг сонгов. Сумдаас ирүүлсэн албан тоотыг Хавсралт 1-д хавсаргав.

### **1. Малчдын бүлэгтэй малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах, гэрээг дүгнэх, хариуцлага болон урамшууллын механизмыг хэрэгжүүлэх**

Малчдын өрхийн зэрэгцээ нутагладаг байдал, хамтран ажиллах эв нэгдэл, бүлгийг удирдах ахлагчийн үр чадвар зэргийг харгалзан 5-10 өрхийн гишүүнчлэлтэй малчдын бүлгийн зохион байгуулалтад оруулна. Малчдын бүлгийн гэрээгээр ашиглах бэлчээрийн хил заагийг хөрш малчидтай зөвшилцөж, БИНХ-аар хүлээн зөвшөөрсний дараа сумын засаг дарга малчдын бүлэгт бэлчээрийг урт хугацааны гэрээгээр ашиглуулах тухай захирамж гаргаж шийдвэрлэнэ. Үүний дараа малчдын бүлгийн малчид жилд малынхаа тоог жилд 5-аас доошгүй хувиар цөөрүүлж бэлчээрийн даац ачааллыг бууруулсан байхаар гэрээнд тусгаж гэрээний биелэлтэд сумын газрын даамал, ХААТ-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, БОХУБ, багийн засаг дарга нар хяналт тавьж ажиллана. Ингэж цөөлсөн малын тоог сумын МЭҮН-ийн МЭНС-д оруулж борлуулсан малын тоогоор баталгаажуулан нэг хонин толгойд зохих ёсны урамшуулал буюу эко системийн төлбөр хэлбэрээр олгох юм. Урамшууллыг сумын малын тоо, толгойн албан татвараас олгохоор туршиж үзнэ.

### **2. Түүхий эдийн чанар, гарал, үүслийг хянаж баталгаажуулах нэг цэг ажиллуулах /цэгийн байршлыг тогтоох, хашаа, пүүгээр хангах, ХАА-н тасаг, МЭТ, МЭҮН-ийг нэг цэгт ажиллуулахад дэмжлэг үзүүлэх/**

Нэг цэгийн үйлчилгээ гэж борлуулах мал, түүхий эдээ малчид сумын төвлөрсөн нэг цэгт авчран эрүүл ахуй, чанарын хянан баталгаажуулалтад

оруулан гарал үүслийн ба эрүүл мэндийн гэрчилгээ авдаг, баталгаажуулсан мал, түүхий эдийг түнш боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах шинэлэг тогтолцоог нэвтрүүлж төлөвшүүлэхийг хэлнэ.

Сумын ЗДТГ-ын газраас нэг цэгт мал, түүхий эд цуглуулах хашаа, хороо, агуулах, мал, түүхий эд жинлэх зохих хэмжээний жин, пүүгээр түр хангах, шаардлагатай гарвал ажиллах хүн хүчнээр хангах туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллана гэсэн үг.

Сумын нэг цэгт авчирсан мал, түүхий эдийн эрүүл мэндийн үзлэг, чанарын хяналт баталгаажуулалтад МЭТ, ХААТ-ийн зохих мэргэжилтнүүд, МЭҮН-ийн малын эмч нарыг оролцуулахад дэмжлэг үзүүлж ажиллана гэсэн үг. Мал, түүхий эдийн эрүүл мэндийн үзлэг, чанарын хяналт баталгаажуулалтын үндсэн дээр гарал үүсэл, эрүүл мэндийн гэрчилгээг олгож ажиллана. Нэг цэгийн ажилд гэрээт үйлдвэрийн газрын төлөөллийг урьж оролцуулна.

### **3. Хамтран ажиллах хоршоог сонгох, түүний засаглалыг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, шаардлагатай тохиолдолд хоршоо дэмжих сангаас зээл олгох**

Нэг цэгт авчирч төвлөрүүлсэн мал, түүхий эдийг гэрээт үйлдвэрийн газарт борлуулах ажлыг малчдын хоршоогоор дамжуулан хийж гүйцэтгэнэ. Ийм учраас хоршооны үйл ажиллагааг дэмжиж сумын ЗДТГ-аас хоршоог хэмжих сангаас хөнгөлөлттэй зээл олгох, мөн хоршоог гадаад, дотоодын төсөл, хөтөлбөрт хамруулан дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх бүхий л дэмжих хэлбэрийг бүрэн ашиглаж ажиллана гэсэн үг.

### **4. Малын тоо толгойн албан татварын орлогыг Төсвийн хуулийн 60.2.8-д заасны дагуу УАӨ-д дасан зохицох үйл ажиллагаа, түүний дотор малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх сонирхлыг дэмжих эко системийн үйлчилгээний төлбөрийг мал борлуулсны урамшуулал хэлбэрээр татвар төлсөн малчдад зарцуулах**

Төсвийн тухай хуулийн 60.2.8 заалтын дагуу малын тоо, толгойн албан татвараас бэлчээрийн менежментийг сайжруулах зорилгоор зарцуулж болно гэсэн заалтыг хэрэгжүүлэх үүднээс бэлчээрийн даац, ачааллыг бууруулж байгаа малчдын бүлгийн гишүүн малчдын борлуулсан малд урамшуулал буюу эко системийн үйлчилгээний төлбөрийг олгож малчдын зах зээлд малаа борлуулах ажлыг дэмжиж эрчимжүүлнэ гэсэн үг.

**5. УАӨ-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох чиглэлээр боловсруулах үйлдвэр, хоршоо, малын тэжээл үйлдвэрлэгчид, мал эмнэлэг, малын чанар, үржлийн ажил, тээвэр, зоорины үйлчилгээ үзүүлэгчид, зуучлагчидтай хамтран ажиллаж, орон нутагт оруулах хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх**

Тухайн малчдын бүлэг /байгууллага/ дээр дурдсан байгууллагуудын алинтай ямар хэлбэрээр хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх, харилцан ашигтай ажиллах чиглэлд зуучлах, хамтран ажиллах боломж нөхцөлийг олгоход тусалж ажиллана.

**6. Хурга махлуулж, зах зээлд борлуулах**

Өсвөр насны малыг эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд төллөсөн эх малыг бэлчээрийн ургамал идүүлсний дээр нь нэмэгдэл тэжээлээр тэжээж малласнаар хургыг богино хугацаанд махлуулж нядалгын жинд хүргэж зах зээлд бэлтгэн нийлүүлэх боломж байгааг ашиглана гэсэн үг. Хурганы мах зөөлхөн, амттайгаас гадна холестрины хэмжээ харьцангуй бага байдгаараа хүний эрүүл мэндэд ач тустай.

**7. Малчдын бүлгийг гэрээлсэн бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтоох нь**

Малчдын бүлгийг гэрээлсэн бэлчээрийн түвшинд нь шүлхий, бог малын мялзан зэрэг гоц халдварт болон бусад халдварт өвчнөөс мал сүрэг нь эрүүл, тайван болохыг тусгай арга зүйн дагуу тогтоож малын мах, түүхий эдийг зах зээлд үнэ хүргэн борлуулах, цаашид дотоод зах зээл болон экспортод гаргах махны хэмжээг нэмэгдүүлэх боломж байгааг туршин хийнэ гэсэн үг.

**Хүснэгт 3.1 УАӨ-д дасан зохицох, зах зээлтэй холбох загвар үйл ажиллагааг БСТ-с туршиж, хэрэгжүүлэхээр сонгогдсон сумд**


Аймгийн нэр	Сумын нэр	Албан бичгийн хариу	5 шалгуураас зөвшөөрсөн шалгуурын тоо
Завхан	Шилүүстэй	Ирүүлсэн	5
	Алдархаан	Ирүүлсэн	5
Ховд	Дарви	Ирүүлсэн	5
	Эрдэнэбүрэн	Ирүүлсэн	5
Дорнод	Баянтүмэн	Ирүүлсэн	5
	Чойбалсан	Ирүүлсэн	5
Сүхбаатар	Халзан	Ирүүлсэн	5
	Түвшинширээ	Ирүүлсэн	5

## **ДӨРӨВ.** УУР АМЬСГАЛД ТЭСВЭРТЭЙ ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛИЙН ЗАРЧМААР ХЭРЭГЖҮҮЛЭХ НЬ

Сонгогдсон 8 сумдад хэрэгжүүлэх доорх загвар үйл ажиллагааны агуулгыг дор оруулав. Үүнд:

1. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх бэлчээр ашиглалтын гэрээ, малчдын зүгээс гэрээний үүргээ хэрэгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх урамшуулал /эко системийн үйлчилгээний төлбөр/
2. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг тогтоох
3. Хурга махлуулж өсвөр насны малыг эдийн засгийн эргэлтэд оруулах
4. Мал, ноолуурыг нэг цэгт төвлөрүүлж, хоршоогоор дамжуулан худалдан борлуулах
5. Төсвийн хуулийн 60.2.8-д заасан малын тоо толгойн албан татвараас санхүүжин сумдад хэрэгжүүлэх боломжтой 11 чиглэлийн УАТХ -н загвар үйл ажиллагаанууд

## 4.1 БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ, УРАМШУУЛЛЫН МЕХАНИЗМ




### ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛ /ТХХМТ/

Оролцоо/хөрөнгө оруулалт:	Хүртэх өгөөж:
<b>ТӨР</b> -сумын Засаг дарга, Газрын даамал, Хөдөө аж ахуйн тасаг (ХААТ)-ийн бэлчээр хариуцсан мэргэжилтэн, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Ус цаг уурын харуул, Багийн Засаг дарга	
Бэлчээр ашиглалтын гэрээг жил бүр дүгнэх	Зохистой ашиглалтыг хариуцлагатай болгосноор бэлчээрийн чанар сайжирна,
Мал борлуулалтын урамшууллаар гэрээний биелэлтийг дэмжих	Малын тоо бэлчээрийн даацад нийцэж, доройтол, цөлжилт буурна
Төсвийн хуулийн 60.2.8-д заасны дагуу бэлчээр, худаг ус, оготно, царцаатай тэмцэхэд хөрөнгө оруулалт гаргах	Бэлчээр, усны нөөцийн зохистой ашиглалт, хамгаалалт сайжирна
<b>ХУВИЙН САЛБАР:</b> Газар зохион байгуулалт (ГЗБ), кадастр, зураглал, худаг усны мэргэжлийн компаниуд, сургалт, судалгааны мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид	
Гэрээгээр ашиглагчдын бэлчээр, усны нөөцийг хэмжих, зураглах	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
Бэлчээр, усны нөөцийг зохистой ашиглах сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
<b>МАЛЧИН:</b> Малчдын бүлгийн гишүүд, эрчимжсэн, хагас эрчимжсэн МАА эрхлэгчид	
Гэрээний үүргээ дүгнүүлэх	Бэлчээрээ зохистой ашиглах хариуцлага сайжирна
Мал борлуулалтын урамшуулал авах	Мал борлуулалт өсөж, цөөн чанартай малаас илүү орлого олно
ГЗБ-н жилийн төлөвлөгөөнд Төсвийн хуулийн 60.2.8-ын дагуу саналаа тусгах	Төсвийн хуулийн 60.2.8-ын дагуу сумаас оруулах хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх



## “Төмөртний нуруу” малчдын бүлгийн гэрээт бэлчээр



Малчдын бүлгийн гэрээгээр ашиглаж байгаа бэлчээрийн зургийн жишээ

### БЭЛЧЭЭР АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2022 оны 09 сарын 4-ны өдөр

Батлав.  
Засаг дарга *[Signature]* /О.ГАНЦОЖ/

Гэрээний дугаар:

НЭГ ТАЛААС *Довь* аймгийн *Дорно* сумын Засаг дарга  
(цаашид "Өмчлөгч" гэх), НӨГӨӨ ТАЛААС *Довь* аймгийн *Дорно* сумын  
малчдын бүлэг, нөхөрлөл *Дорногийн Улаан Бүлэг* (цаашид "Ашиглагч" гэх)-д бэлчээр  
гэрээгээр ашиглуулах, хамгаалах талаар харилцан тохиролцож, Монгол улсын Иргэний  
хуулийн 189.1, 189.5, 481.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын  
тухай хуулийн 59.1.17, Газрын тухай хуулийн 45.1, 52.2, 52.3, Байгаль орчныг хамгаалах  
тухай хуулийн 4.1.3, 4.2.3, 17.2.2, 19.7, 26.3, 27.1, 27.7, 48.1.1, 50.4, 50.5, 52.1, 54.1, Тусгай  
хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 17.2, 21.2, 21.2, 29.2, 30.10, 33.1, Усны тухай  
хуулийн 13 дугаар зүйлийн 22.6, 23.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн 5.4, 18 дугаар  
зүйлийн 18.3, 18.4 дэх заалт, Малын тоо толгойн албан татварын тухай хуулийн 7.1,  
Төсвийн тухай хуулийн 60.2.8 дахь заалт, сумын *Дорно*-ын 202 оны 09 тоот тогтоол, Засаг  
даргын 2022 оны 09 тоот захирамжийг тус тус үндэслэн энэхүү гэрээг байгуулав.

#### Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү гэрээгээр малчдын бүлэг, байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлд  
байгалийн бэлчээрийг ашиглуулах, хамгаалах, түүнчлэн гэрээний хэрэгжилт, үүргийн  
биелэлтэд хяналт тавих, дүгнэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

#### Хоёр. Бэлчээр ашиглалтын зориулалт, хэмжээ, байршил

2.1 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийг зөвхөн мал аж ахуй эрхлэх зориулалтаар  
ашиглана.

2.2 Ашиглагчаас гэрээгээр ашиглуулах бэлчээрийн талбайг *37,000* га-аар тогтоов.

2.3 Бэлчээрийн зуны дээд ургацыг олон жилийн дунджаар *ц/га*;

2.4 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн даацыг хонин толгойд шилжүүлснээр дараах  
жишиг үзүүлэлтээр тогтоов. Үүнд:

2.4.1.1 Өвөлжөөний бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.2 Хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой
2.4.1.3 Өвөлжөө-хаваржааны бэлчээр	га, даац	хонин толгой

2.5 Гэрээгээр ашиглуулах бэлчээрийн даацын тооцоонд өвсөн тэжээлт зэрлэг хөхтөн  
амьтдыг оруулж тооцно.

2.6 Бүлгийн гишүүдийн мэдээлэл (Хавсралт 1), бүлгийн гишүүн ерхийн малын тооны  
мэдээлэл (Хавсралт 2), гэрээт бэлчээрийн байршил, хэмжээ, улирлын ашиглалтын зураг  
(Хавсралт 3), гэрээт бэлчээрийн төлөв байдлын суурь мэдээлэл (Хавсралт 4), бэлчээрийн  
даацад нийцүүлэх үүднээс малын тоог цөөлөх ... жилийн төлөвлөгөө (Хавсралт 5)-г тус тус  
хавсаргав.

2.7 Гэрээний хүчинтэй хугацаа сунгалтгүйгээр 15 /арван тав/ жил байна.

#### Гурав. Өмчлөгчийн эрх, үүрэг

3.1. Өмчлөгч нь дараах эрх, үүрэгтэй.

3.1.1. Гэрээлсэн бэлчээрт эрх бүхий этгээдийн тогтоосон цэгт бэлчээрийн ургац,  
даацыг жил бүр тогтоох

3.1.2. Сүүлийн 5 жилийн дундаж ургацыг үндэслэн байвал зохих малын тооны дээд  
хязгаарыг шинэчлэн тооцож ашиглагчид хүргүүлэх

## Малчдын бүлгийн бэлчээр ашиглалтын гэрээний нүүр хуудас, жишээ

### Хүснэгт 4.1 Малыг аж ахуйн эргэлтэд оруулан борлуулж, бэлчээрийн даацыг тохируулах, малчдын орлогыг нэмэгдүүлэх загвар тооцоо

Үзүүлэлт, 5 жилээр	1	2	3	4	5	Өсөлт %
Малчин өрхийн малын тоо, хонин толгойгоор	678	644	612	581	552	-19
Малчин өрхийн нийт орлого, сая төг	17.6	25.6	25.4	25.2	25.0	18
Өрхийн хэрэглэсэн бүтээгдэхүүн, сая төг	3.4	3.4	3.4	3.4	3.4	3.4
Өрхийн мөнгөн орлого, сая төгрөг	14.2	22.2	22.1	21.9	21.7	14
Малын тооны бууралтад ногдох орлого, сая. төг	0	3.4	3.3	3.1	3.0	
1 хонин толгойд ногдох мөнгөн орлого, мян. төг	21	33	34	36	37	78

### Хүснэгт 4.2 Малын тоог өсгөдөг одоогийн тогтолцоо

Үзүүлэлт, 5 жилээр	1	2	3	4	5	Өсөлт, %
Малчин өрхийн малын тоо, хонин толгойгоор	678	712	747	784	824	22
Малчин өрхийн нийт орлого*, сая төгрөг	17.6	17.6	17.6	17.5	17.4	-1.1
Өрхийн хэрэглэсэн бүтээгдэхүүн, сая төгрөг	3.4	3.4	3.4	3.4	3.4	0.0
Малчин өрхийн мөнгөн орлого, сая төгрөг	14.2	14.2	14.2	14.1	14.0	-1.3
1 хонин толгойд ногдох мөнгөн орлого, мянган төгрөг	21	21	20	19	18	-15

Шинэ загвараар малын тоо буурч байгаа боловч, түүнийг дагаад малын бэлчээрийн ачаалал, дутуу хооллолт буурч, малын ашиг шим, чанар дээшилж, борлуулалт нэмэгдсэнээр малчин өрхийн орлого, нэг малаас авах орлого буюу бүтээмж одоогийн малаа өсгөдөг загвартай харьцуулбал хамаагүй өндөр буюу малчдад ашигтай, байгальд ээлтэй байна.

## **Малын борлуулалтыг урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр**

Экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/ гэдэг нь газар, байгалийн нөөцийг өмчлөгчийн зүгээс өөрийн ашиглаж байгаа газар, байгалийн нөөцийг зохистой ашиглаж, хамгаалах хүчин зүтгэл гаргаж байгаа буюу ийм үйлчилгээ үзүүлж байгаа этгээдэд олгож байгаа татаас, төлбөрийн тогтолцоо юм.

НҮБ-н Хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилттэй “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь, ENSURE” төслийн хүрээнд Бодлого судлалын төвөөс малаа аж ахуйн эргэлтэд оруулж борлуулан бэлчээрийн ачааллыг бууруулж байгаа малчдыг урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөрийг түршсан юм. Малаа борлуулсныг мал эмнэлгийн гэрчилгээнд үндэслэн тогтоож, хонин толгой дутам 750 төгрөгийн урамшууллыг олгож байгаа нь малыг аж ахуй эргэлтэд оруулахыг урамшуулахаас гадна хүнсэнд нийлүүлэх мал бүрд эрүүл мэнд, гарал үүслийн гэрчилгээ авах хөшүүрэг болж байна.

ЭСҮТ-ийг малын тоо толгойн албан татварт тусгаж хэрэгжүүлэхийн давуу тал

- Байгаль орчныг хамгаалах, бэлчээрийн менежментэд хөрөнгө зарах Төсвийн хуультай нийцсэн
- Байгаль хамгаалахад орон нутагт тулгарч буй гол бэрхшээл болсон санхүүгийн дутагдлыг шийдэх боломжтой
- Биологийн олон янз байдалд учирч байгаа гол аюул бэлчээрийн доройтлыг бууруулна
- Хүлэмжийн хийг бууруулна, малын тарга хүч ашиг шим, малчдын орлого, хүнсний хангамжийг нэмэгдүүлэх гээд олон эерэг үр дагавартай

Малын борлуулалтыг урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр гардуулж байгаа нь



*Цогт сумын төслийн идэвхжүүлэгч Н.Бибиш, малчдын ТББ-н захирал Л.Мөнхжаргал, малчин С.Адьяа, Бодлого судлалын төвийн зөвлөх Б.Даваамөнх нар мал борлуулсны урамшууллыг гардуулж байгаа нь*

**БЭЛЧЭЭР АШИГЛАЛТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛЖ, МАЛЫН ТООГ БЭЛЧЭЭРИЙН ДААЦАД НИЙЦҮҮЛЭХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭХЭД НЬ ЭКОСИСТЕМИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨРИЙГ МАЛ БОРЛУУЛСНЫ УРАМШУУЛАЛ ХЭЛБЭРЭЭР ОЛГОСНЫ БОДИТ ҮР ДҮН, Даян дэлхийн байгаль орчны сан, НҮБХХ-н дэмжлэгтэй ENSURE төлийн 13 сумын жишээн дээр**

13 сумын дүнгээр төсөлд хамрагдсан малчид малынхаа тоог 2020 онд 19.7%, 2021 онд 4.6%, 2020-2021 оны нийлбэр дүнгээр 23.4% бууруулсан юм.

Харин төсөлд хамрагдаагүй малчид малынхаа тоог 2020 онд 13%, 2021 онд 0.3%, 2020-2021 оны нийлбэр дүнгээр 13.3% бууруулсан юм. Ийнхүү байгаль цаг агаарын ижил нөхцөлд оршиж байсан төсөлд хамрагдсан малчид хамрагдаагүй малчдаас малынхаа тоог 2020-2021 оны нийлбэр дүнгээр 10.1 хувь илүү бууруулсан нь төслийн бодит үр дүн юм. Бэлчээрийн ачаалал буурснаар малын тэжээл хангамж, ашиг шим сайжирч, малчдын орлогыг байгальд ээлтэй аргаар тогтвортой өсгөх суурь тавигдсаны зэрэгцээ биологийн олон янз байдалд учирч байсан гол аюул, сөрөг нөлөө багасаж, хүлэмжийн хийн ялгарал 29 мянга гаруй жишиг тонноор буурсан юм.

### Төсөлд хамрагдсан малчдын бүлгийн малын тооны өөрчлөлт, хонин толгой

№	Сум	Төсөлд хамрагдсан малчдын бүлгийн малын тоо, хонин толгой			Төсөлд хамрагдсан малчдын бүлгийн малын тооны өөрчлөлт, %			Хүлэмжийн хийн бууралт, жишиг CO2, тонн
		2019	2020	2021	20 / 2019	2021 / 2020	2021 / 2019	
1	Тосонцэнгэл	54,216	52,157	55,929	-3.8	7.2	3.2	62.6
2	Их-Уул	85,744	55,502	61,018	-35.3	9.9	-28.8	4,903.3
3	Шинэжинст	30,466	26,951	14,038	-11.5	-47.9	-53.9	1,913.4
4	Баян-Өндөр	23,742	18,152	15,470	-23.5	-14.8	-34.8	746.8
5	Баян-цагаан	67,247	27,423	19,682	-59.2	-28.2	-70.7	6,721.6
6	Баацагаан	57,408	38,845	30,558	-32.3	-21.3	-46.8	1,699.0
7	Хайрхан	57,620	49,518	55,853	-14.1	12.8	-3.1	(300.3)
8	Өлзийт	83,759	65,446	75,706	-21.9	15.7	-9.6	2,632.4
9	Эрдэнэмандал	103,671	89,092	93,353	-14.1	4.8	-10.0	247.6
10	Батцэнгэл	99,480	100,550	100,824	1.1	0.3	1.4	(335.4)
11	Эрдэнэ	32,601	28,562	21,023	-12.4	-26.4	-35.5	607.2
12	Цогт	54,445	46,889	37,424	-13.9	-20.2	-31.3	1,587.3
13	Чандмань	62,952	53,819	42,082	-14.5	-21.8	-33.2	8,684.6
<b>Дүн</b>		<b>813,352</b>	<b>652,903</b>	<b>622,960</b>	<b>-19.7</b>	<b>-4.6</b>	<b>-23.4</b>	<b>29,170.2</b>

Эх сурвалж: Сумдын 2020, 2021 мал тооллогын дүн

### Төсөлд хамрагдаагүй малчдын малын тооны өөрчлөлт, хонин толгой

№	Сум	Төсөлд хамрагдаагүй малчдын малын ТОО, хонин толгой			Төсөлд хамрагдаагүй малчдын малын тооны өөрчлөлт, %		
		2019	2020	2021	2020/2019	2021/2020	2021/2019
1	Тосонцэнгэл	336,163	310,574	354,986	-7.6	14.3	5.6
2	Их-Уул	481,412	465,757	489,576	-3.3	5.1	1.7
3	Шинэжинст	185,389	144,908	134,934	-21.8	-6.9	-27.2
4	Баян-Өндөр	162,843	143,869	123,222	-11.7	-14.4	-24.3
5	Баян-цагаан	223,173	155,488	112,574	-30.3	-27.6	-49.6
6	Баацагаан	381,928	258,796	225,802	-32.2	-12.7	-40.9
7	Хайрхан	729,139	606,832	632,557	-16.8	4.2	-13.2
8	Өлзийт	470,093	444,310	509,532	-5.5	14.7	8.4
9	Эрдэнэмандал	815,436	686,386	726,614	-15.8	5.9	-10.9
10	Батцэнгэл	692,524	648,168	667,022	-6.4	2.9	-3.7
11	Эрдэнэ	242,050	215,017	179,365	-11.2	-16.6	-25.9
12	Цогт	309,394	297,962	232,682	-3.7	-21.9	-24.8
13	Чандмань	218,976	186,614	162,234	-14.8	-13.1	-25.9
<b>Дүн</b>		<b>5,248,519</b>	<b>4,564,680</b>	<b>4,551,100</b>	<b>-13.0</b>	<b>-0.3</b>	<b>-13.3</b>


Эх сурвалж: Сумдын 2020, 2021 мал тооллогын дүн

## 4.2 МАЛЧДЫН БҮЛГИЙН ГЭРЭЭТ БЭЛЧЭЭРИЙН ТҮВШИНД ХАЛДВАРТ ӨВЧИНГҮЙ, ЭРҮҮЛ, ТАЙВАН НУТАГ ТОГТООХ

**Зорилго:** Экспортын хориг бүхий гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг, мал амьтнаас хүнд халдварладаг (зооноз) өвчин болох бруцеллёз, сүрьеэ өвчнөөс эрүүл, тайван нутгийг тогтоох

Энэ загвар үйл ажиллагаа нь Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллага (OIE)-аас тавьж байгаа хамгаалагдсан аж ахуйг бэлчээрийн МАА-д нэвтрүүлэх эхний алхам юм.

**Туршсан байдал:** АХБ-ны санхүүжилттэй “Хоршилтод суурилсан ХАА-н тогтвортой үйлдвэрлэл” төслийн хүрээнд Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд малчдын 3 бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд гоц халдварт шүлхий, бог малын мялзан, хонь, ямааны цэцэг, зооноз халдварт бруцеллёз, сүрьеэ өвчингүй, эрүүл, тайван нутгийг 2021 онд тогтоож, эрүүл сүрэгтэн батламж олгон ажиллуулсан. Мах, түүхий эдээ зах зээлд үнэ хүргэн борлуулж одоо хүртэл эрүүл, тайван байдлаа тогтвортой хадгалан ажиллаж байх жишээтэй.




Тарант холбоо малчдын бүлгийн гэрээлсэн бэлчээрийн зураглал



Халдварт өвчний шинжилгээнд зориулан үхрээс цус авч байгаа нь




Бог малын мялзан өвчний шинжилгээнд зориулсан цусны ийлдсэнд ЕЛИЗА урвал УМЭАЦТЛ-т тавьж байгаа нь



Зураг. Шүлхий өвчнөөр “Эрүүл сүрэгтэн” батламж

**Оролцох талууд:** Адапт төсөл, МЭЕГ, МЭАЦТЛ, Аймгийн МЭГ, сумын МЭТ, МЭҮН, Хоршоо, малчдын бүлэг, БСТ





**ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛ /ТХХМТ/**

<b>Оролцоо/хөрөнгө оруулалт:</b>	<b>Хүртэх өгөөж:</b>
<b>ТӨР-</b> Мал эмнэлэг ариун цэврийн төв лаборатори (МЭАЦТЛ), Аймгийн МЭГ, сумын Засаг дарга, МЭТ, БОХУБ, Газрын даамал, Багийн Засаг дарга	лаборатори (МЭАЦТЛ), Аймгийн МЭГ, сумын Засаг дарга, МЭТ, БОХУБ, Газрын даамал, Багийн Засаг дарга
МБ-ийн гэрээт бэлчээрийн зураглалыг гаргах	МБ-ийн гэрээт бэлчээрийн хил зааг, хэмжээ тодорхой болно.
МЭАЦТЛ малын дээжид шинжилгээ хийж өвчнөөс эрүүл байгааг баталгаажуулах	Халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг тогтоох үндэс болох
Аймгийн МЭГ шинжээчийн баг ажиллуулах, халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг тогтоох, эрүүл сүрэгтэн гэрчилгээ олгох шийдвэрүүд гаргах, тогтвортой байдлыг хадгалах стратегийг боловсруулах, хэрэгжүүлэх	Сумын хэмжээнд зах зээлд нийлүүлэх эрүүл, аюулгүй махны хэмжээ нэмэгдэх

МБ-ийн бэлчээрийн халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийг жил бүр дүгнэх, сайжруулах	МБ-ийн бэлчээрийн халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдал үргэлжилж малын эрүүл мэнд сайжирна.
Бүлгийн малын шилжилт хөдөлгөөнд МЭТ-ийн тавих хяналтыг сайжруулах, тандах судалгааг зохион байгуулах	Малын эрүүл мэнд сайжирна.
Төсвийн хуулийн 60.2.8-д заасны дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын эрүүл мэндийг хамгаалахад хөрөнгө оруулалт гаргах	Сумын малд халдварт болон бусад өвчний гаралт, тархалт багасна.
<b>ХУВИЙН САЛБАР:</b> МЭХ, ХМЭХ, Мал эмнэлгийн дундын хоршоо, Сумын МЭҮН бүхий компаниуд, сургалт, судалгааны мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид	
Халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг тогтоох хүрээнд малд эмнэл зүйн үзлэг хийх, шинжилгээний цус болон бусад дээжийг авч бэлтгэн лабораторид илгээх	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
Халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийг хэрэгжүүлэх хүрээнд малын шилжилт хөдөлгөөнд тавих хяналтаа сайжруулах	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
Халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийг хэрэгжүүлэх хүрээнд малд зохих хугацаанд тандах судалгааг явуулах	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
Халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийг хэрэгжүүлэх чадавхыг сайжруулах сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
<b>МАЛЧИН:</b> Малчдын бүлгийн гишүүд, эрчимжсэн, хагас эрчимжсэн МАА эрхлэгчид	

Бэлчээр нь халдварт өвчингүй, эрүүл, тайван нутаг болж, эрүүл нутгийн гэрчилгээ авч ашиглан мал, махаа зах зээлд үнэ хүргэж борлуулах боломж нэмэгдэх	Малчдын орлого нэмэгдэх
Зах зээлд нийлүүлэх эрүүл, аюулгүй мах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний хэмжээ нэмэгдэх	Мал борлуулалт өсөж, цөөн чанартай малаас илүү орлого олно
Зооноз халдварт өвчний гаралт, тархалт багасах	Малчид, фермерийн эрүүл мэнд сайжрах
ГЗБ-н жилийн төлөвлөгөөнд Төсвийн хуулийн 60.2.8-н дагуу саналаа тусгах	Төсвийн хуулийн 60.2.8-н дагуу сумаас оруулах хөрөнгө оруулалтаас ашиг хүртэх

### 4.3 ХУРГА МАХЛУУЛЖ ӨСВӨР НАСНЫ МАЛЫГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ

Бэлчээрийн даац хэтрэлт, тэжээлийн архаг дутагдлаас малын ашиг шим, үнэ цэнэ буурч байгаа нь



### Малын тооны өсөлтийг дагаад бэлчээрийн тэжээлийн хүрэлцээ буурч буй нь

Малын тоо толгой огцом өссөн явдал бэлчээрийн даац хэтрэх гол шалтгаан болж байна. Малын тоо 10 хүрэхгүй жилийн дотор хоёр дахин

нэмэгдэж, бэлчээрийн доройтлын улмаас малын тэжээлийн хангамж зохистой тэжээллэгийн шаардлагаас үлэмж доогуур түвшинд хүрчээ. 2022 оны байдлаар малын тоо 70 гаруй сая тоо толгой болсноор тэжээл хангамж 45% болж, 1 хонины тэжээлийг 2.2 хонь хуваан идснээс давжаарч, ашиг шим буурч байна.


Ухаалаг бодлого биш, харин зуд малын тоог “зохицуулж”, тэжээлийн архаг дутагдлыг зөөллөж ирлээ.

- 2004-2014 онд хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг-р буурсан
- 1990-2016 онд богийн гулуузны жин 13.9% буурсан /ХХААХҮЯ, 2018/
- Мал нь улсын нийт хүлэмжийн хийн 48.5% ялгаруулж гол “бохирдуулагч” болсон
- Хил дамнасан өвчний гаралт буурахгүй, экспортод сөргөөр нөлөөлж байна
- Бэлчээрийн даац их хэтэрснээс гулуузны чанар муудаж, өөхний хувийн жин нэмэгдэж, махны хувийн жин буурч байгаагаас экспортын зах зээлд үнэлгээ нь унаж байна. Ийнхүү малын амьдын жин буурсны алдагдал 14%, гулуузны чанар муудсаны 33%-ийг нийлүүлж нийт одоогийн мал нь бэлчээрийн тэжээл бүрэн хангамжтай байх үеийн малтай харьцуулбал 42%-ийн алдагдалтай байна.

Бэлчээрийн даац хэтрэлт, тэжээлийн архаг дутагдлаас үүдэж малын ашиг шим, үнэ цэнэ буурч байгаа нь



### ХУРГАНЫ МАХ БЭЛТГЭЛ



Малчдын орлогыг бууруулахгүйгээр малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэн цөөлөх дөт зам нь хонийг эрт төллүүлэн, төллөсөн эх малыг тэжээж жилбэжүүлэн, сүү шимээр дамжуулан хургыг махлуулан 7-8 сартайд нь эдийн засгийн эргэлтэд оруулах явдал юм. Ингэснээр малыг бэлчээрт заавал 3-4 жил барих шаардлагагүй болж, бэлчээрээ олон малаас чөлөөлж хамгаалах боломжтой болно. Хурганы махны борлуулалтыг дараах хэлбэрээр зохион байгуулах боломжтой. Үүнд:

- Эмнэлэг, сургууль, цэцэрлэг гэх мэт сумын төсөвт байгууллагын хэрэгцээнд худалдаж авах
- Хурганы махны давуу чанарыг сайтар сурталчилсны үндсэн дээр төвлөрсөн зах зээлд нийлүүлэх
- Экспортод гаргах

### ХУРГАНЫ МАХ БЭЛТГЭЛИЙН УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ



Хурганы мах бэлтгэлийн талаар 7-р сард малчдад сургалт явуулах хамтарч ажиллах малчдаа сонгоно

Сонгогдсон малчдын эх сүрэгт IX/15-Х/0-нд зоотехникийн үзлэг шинжилгээ, ангилалт хийж шилмэл хээлтүүлэгч сонгож авна

Амьдын жин, ашиг шимийн хувьд шилмэл хуц сонгож Х/01-ээс хээлтүүлэгт оруулна

Өсөлт торнилт сайтай махлаг хурга

Хурга борлуулах нь мах үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх загвар болох нь

Мах үйлдвэрлэлийг хонин сүргийн эргэлтийн 4 хувилбараар гаргав Үүнд:

**А-** малын тоог жилд дунджаар 10% өсгөж байгаа одоогийн нөхцөл

**Б-Г** малын тоог өсгөхгүйгээр барьж, эр хургыг түлхүү борлуулах 3-н хувилбар

#### Хүснэгт 4.3.1 Хурга борлуулснаар мах үйлдвэрлэл, орлого нэмэгдэж, шаардагдах бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ багасах нь, 100 хонь тутам

Хувилбарууд	Сүрэгт хээлтэгчийн эзлэх %,	Хурга борлуулах хувь	Мах үйлдвэрлэл, кг	Шаардагдах бэлчээрийн тэжээлийн хэрэгцээ			Махны орлого, сая төгрөг	Махны орлогын өсөлт	
				Нийт тэжээл, цн	Нийт талбай, га	100 кг маханд шаардагдах бэлчээр, га		Хувиар %	Сая төгрөгөөр
<b>А</b>	45%	Үгүй	526	607	289	55	3.58	-	-
<b>Б</b>	45%	Эр 6% Охин 3%	709	584	278	39	4.82	34.7	1.24

<b>В</b>	60%	Эр 72% Охин 5%	884	602	287	32	6.01	68.0	2.43
<b>Г</b>	70%	Эр 95% Охин 16%	1001	614	293	29	6.81	90.3	3.23

**Тайлбар:** Малчдын борлуулж буй махны 1 кг-ын үнийг 2019-2021 оны 3 жилийн улсын дундаж 6800 төгрөг, бэлчээрийн ургацыг 2016-2020 оны 5 жилийн улсын дундаж ургац 2.1 цн, махлуулсан эр хурганы намрын амьдын жинг дунджаар 42.5 кг (нийт махлуулсан эр хурганы 50% нь 45 кг, 50% нь 40 кг хүрэх тооцоо), нядалгааны гарцыг 43%-р тус тус тооцов.

**А-с Г-д** шилжих дутам мах үйлдвэрлэл нэмэгдэж, шаардагдах бэлчээр багасан бүтээмж, орлого нэмэгдэж байна. Тухайлбал ижил 100 кг махыг Г хувилбараар 29 га бэлчээрт үйлдвэрлэж байгаа нь одоогийн нөхцөл болох **А** хувилбарын 55 га-аас 26 га-аар бага буюу бэлчээрийн хэрэгцээг 47% бууруулж байна. Хамгийн гол нь малчдын мах үйлдвэрлэлээс олох орлого 100 хонь дутам одоогийнхоос 1.2-3.2 сая төгрөгөөр нэмэгдэж байна.

### **Хурга борлуулах нь цөөн малаас илүү орлого олох загвар болох нь**

Хурга борлуулах замаар МАА-н үндэс болсон бэлчээрээ хамгаалж, малчдын амьжиргааг урт хугацаанд тогтвортой дээшлүүлэх боломжтой юм.

Хургыг намар 45 кг амьдын жинд хүргэх зорилгоор:

- Махны чиглэлийн шилмэл омгийн хуцыг хээлтүүлэгчээр ашиглах
- Төллөсөн эр хургатай эх хонийг хоногт 250 грамм чанартай хүчит тэжээлээр 45 хоног нэмэгдлээр тэжээж, эхийг жилбэжүүлэхийн зэрэгцээ бэлчээрт явах зайг багасгах замаар хурганы явдлыг багасгаж махлуулах
- Хургыг 7-р сарын сүүлчээр хургыг эхээс нь ялгаж тусад нь суурь зохион байгуулж сайн бэлчээрт оторлох
- Тэжээлийн зардалд 100 хонь тутамд тооцож 1.1 сая төгрөг, хурганы маллагааны хөлсөнд сарын 0.3 сая төгрөг, Баяд гурван хуц худалдан авахад 0.9 сая төгрөг нийт гарсан зардал 2.3 сая төгрөгийн зардал гарч байна. Хурганы мах үйлдвэрлэлийн орлого, ашгийн тооцоог 500 хоньтой малчин өрхийн жишээн дээр харьцуулан доорх хүснэгтэд гаргав.

### Хүснэгт 4.3.2 500 хоньтой малчин өрхийн хонины махны орлогын харьцуулалт

Үзүүлэлт	Одоогийн нөхцөлд	Эх малын хувийн жинг 70% хүргэж хурга борлуулснаар
Малын тоо, толгойгоор	500	500
Үйлдвэрлэх мах, тонн	2.63	5.0
1 кг махны үнэ, төгрөг	6800	6800
Махны нийт орлого, сая төгрөг	17.9	34.0
Хурга махлуулах зардал сая төгрөг	-	11.5
Бусад шууд зардал*	5.3	5.3
Нийт зардал, сая төг	5.3	16.8
Цэвэр орлого, сая төг	12.6	17.2

\*Үүнд тэжээл, мал эмнэлэг, тээвэр, шатахуун, хариулгын хөлс багтсан бөгөөд хоёр дахь эх үүсвэрийн судалгааны материалыг ашиглав. Харин малчин өрхийн амьжиргааны зардал ороогүй болно.

### ТӨР-ХУВИЙН ХЭВШИЛ-МАЛЧДЫН ТҮНШЛЭЛ /ТХХМТ/

Оролцоо/хөрөнгө оруулалт:	Хүртэх өгөөж:
<b>ТӨР</b> -сумын Засаг дарга, Тамгын газрын дарга, ХААТ-ийн МАА хариуцсан мэргэжилтэн, Багийн Засаг дарга	
Хурганы махыг сумын төсөвт байгууллагын дотоод хэрэгцээнд хэрэглэж хэвших	Сумын эмнэлэг, сургууль, цэцэрлэг зэрэг төсөвт байгууллагын дотоод хэрэгцээнд хурганы мах хэрэглэснээр малын эм вакцины боловсруулалтад ороогүй эрүүл органик гаралтай амтлаг, шүүслэг махаар хангагдах нөхцөл бүрдэнэ
Мал ангилалт	Мал ангилалтыг хийснээр сүргийн чанар сайжирч, нэгжээс авах ашиг шимийн хэмжээ нэмэгдэнэ
Хээлтүүлэгч малын үржлийн чанарыг үнэлэх	Жишигт тэнцсэн үржлийн хээлтүүлэгч үржилд ашигласнаар сүргийн чанар сайжирна
Малын ашиг шимийг түүврээр хэмжиж бүртгэх, үндэсний статистикийн мэдээлэлд хамруулах	МАА-н үйлдвэрлэлийн төлөвлөлт бодитой болно




<b>ХУВИЙН САЛБАР:</b> Мал үржлийн нэгж, сургалт, судалгааны мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчид	
Гэрээгээр малын ангилалт хийх	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, малын чанар, үржлийн ажил үйлчилгээ сайжирч бизнесийн орлого нэмэгдэнэ
Хээлтүүлэгч малын үржлийн чанарыг үнэлэх	Холбогдох мэргэжлийн чадавх, туршлага сайжирна, бизнесийн орлого нэмэгдэнэ
<b>МАЛЧИН:</b> Малчдын бүлгийн гишүүд, эрчимжсэн, хагас эрчимжсэн МАА эрхлэгчид	
Төллөсөн эх мал тэжээж хурга махлуулах	Өсвөр насны малыг эдийн засгийн эргэлтэд оруулснаар мал борлуулалт өсөж, цөөн чанартай малаас илүү орлого олно
	Малчны хотонд цөөн тооны чанартай үржлийн сүрэгтэй болсноор малчдын хөдөлмөр хөнгөвчлөгдөнө

#### 4.4 МАЛЫГ НЭГ ЦЭГТ ТӨВЛӨРҮҮЛЖ, ХОРШООГООР ДАМЖУУЛАН ХУДАЛДАН БОРЛУУЛАХ

##### Нэг цэгээр мал борлуулах үйл ажиллагааны товч мэдээлэл

Сумын Засаг даргатай бэлчээр ашиглалтын гэрээ байгуулж малын тоо толгойг даацад нийцүүлэх үүрэг хүлээсэн малчдын бүлгийн гишүүн өрхийн зах зээлд борлуулах малыг нэг цэгт төвлөрүүлэн хоршоогоор дамжуулан дундын зуучлалгүйгээр боловсруулах үйлдвэр, худалдан авагчдад чанарын урамшуулалтай үнээр борлуулах зорилготой.

## Малын тооноос чанарт шилжих загвар



### Өнөөгийн нөхцөл:

- Гэрээгүйгээс малын тоог өсгөж бэлчээрээ талхална, малын орлого буурна
- Ангилсан түүхий эдийг ялгаварт үнээр борлуулах боломжгүй, чанар сонирхдоггүй
- Түүхий эдийг бөөгнүүлж үнэ өсгөх, зардал хэмнэх боломжийг ашигладаггүй
- Чанар, гарал үүслийн гэрчилгээний үнэмшил, мөшгөх боломж сул.

### Бэлчээрийн гэрээ, 1 цэгийн зохион байгуулалт :

- Малчдын бүлэг гэрээний дагуу бэлчээрээ даацад тохируулж, хариуцлагатай ашиглана
- Малчид хоршоонд нэгдэнэ
- Мал, түүхий эдээ 1 цэгт төвлөрүүлэн ангилалт хийж, чанар, гарал үүсэл, ногоон шалгуурыг баталгаажуулна.

### Шууд гэрээгээр борлуулах тогтолцоо:

- Ногоон шалгуур хангаж мөшгөх боломжтой бүтээгдэхүүнээ сурталчилж, худалдан авагчийг тодруулна /ХАА-н биржээр дамжуулах боломжтой/
- Боловсруулах үйлдвэрт шууд гэрээгээр чанарын урамшуулалт үнээр борлуулна
- Загварыг орон нутгийн хөгжлийн бодлого, ногоон санхүүгээр дэмжинэ.

### ТХХМТ-ийн хүрээнд нэг цэгийн үйл ажиллагаанд оролцогчид

	Оролцогчид	Гүйцэтгэх үүрэг/оролцоо	Хүртэх ашиг
1	Бэлчээрийн гэрээ байгуулсан хоршооны гишүүн малчид	Малчдын бүлгийн хэмжээнд тухайн жилд борлуулах малын тоо, төрлийг урьдчилан гаргаж, нэг цэгээр малаа борлуулах	Мал зарах цаг хугацаа, тээврийн зардал хэмнэнэ Малаа сумандаа орон нутгийн үнээс өндөр үнээр борлуулна Хоршооноос үнийн зөрүү ноогдол ашиг авна орлого нэмэгдэнэ
2	ХАА-н Хоршоо	Нэг цэгийг ажиллуулах, гишүүн малчдын оролцоог хангах, боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулах, малын үнийг хоршооны дансаар дамжуулан малчдад олгох, ноогдол ашиг хуваарилах зэрэг зохион байгуулалтын ажлыг хийх	Хоршооны эрхлэх үйл ажиллагаа нэмэгдэж орлого нэмэгдэнэ Үйл ажиллагаа жигдэрснээр хоршоонд итгэх малчдын хандлага оролцоо сайжирна. Боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан ажилласнаар байнгын түнштэй болно
3	Боловсруулах үйлдвэр буюу мал удалдан авагчид	Нэг цэгээс үйлдвэрийн шаардлага хангасан гарал үүсэл тодорхой, эрүүл малыг орон нутгийн үнээс 5% илүү үнээр худалдан авах	эрүүл гарал үүсэл нь тодорхой нэг цэгт бөөгнөрүүлсэн мал худалдан авснаар зардал хэмнэнэ Байнгын бэлтгэн нийлүүлэгчтэй болно
4	Сумын ХААТ, МЭТ-гийн мэргэжилтэн	Малын гарал үүсэл, эрүүл мэнд, тарга хүчийг нэг цэгт хянаж баталгаажуулна	Зах зээлд эрүүл, гарал үүсэл тодорхой мал нийлүүлж хүнсний аюулгүй байдал дээшилнэ
5	МЭҮН	Малыг нүдээр үзэж эрүүл мэнд, гарал үүслийн гэрчилгээг олгоно	Зах зээлд нийлүүлж байгаа малын эрүүл мэнд, гарал үүсэлд тавих хяналт сайжирна Мал, бүтээгдэхүүний эрүүл мэндийг хянаж баталгаажуулах ажлыг хөнгөвчилж зардал хэмнэнэ

### Нэг цэгээр бог мал худалдсан туршлага. Архангай аймаг Өлзийт сум



Малчид зарласан хугацаанд нэг цэгт малаа авчирч, мал эмнэлгийн үзлэгт оруулж байгаа нь.



Худалдан авах малыг боловсруулах үйлдвэрийн шаардлагын дагуу жинлэж байгаа нь



Нэг удаа 300 бог ачих багтаамжтай зориулалтын машинд ачиж байгаа нь

### Нэг цэгээр үхэр худалдан авсан туршлага. Хэнтий аймаг Баян-Овоо сум



Малаа өөрийн унаагаар нэг цэгт авчирч байгаа нь



Нэг цэгт үхрийг жинлэж хүлээн авч байгаа нь



ХААТ-ийн мал зүйч малын тарга хүч, МЭҮН-ийн эмч эрүүл мэндийн үзлэг нэг цэг дээр хийж байгаа нь



## **4.5 НОЛУУРЫГ НЭГ ЦЭГТ ЦУГЛУУЛЖ, ХОРШООГООР ДАМЖУУЛАН ХУДАЛДАН БОРЛУУЛАХ**

### **Нэг цэгээр ноолуур борлуулах үйл ажиллагааны товч мэдээлэл**

Сумын Засаг даргатай малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх үүрэг хүлээж бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлгийн гишүүн өрхийн тогтвортой ноолуурын стандартын дагуу бэлтгэсэн ноолуурыг нэг цэгт цуглуулан хоршоогоор дамжуулж дундын зуучлалгүйгээр боловсруулах үйлдвэр, худалдан авагчдад чанарын урамшуулалтай үнээр борлуулах зорилготой.

### **Нэг цэгээр борлуулах ноолуурын стандарт**

#### **MNS 0038: 2007 Түүхий эд бэлтгэл Ямааны ноолуурын улсын стандарт**

1. Ямаа самнахаас өмнө бэлтгэл ажлыг хангаж шороо шуурахгүй битүүмжилсэн газар буюу гэр хашаанд заавал дэвсгэр дэвсэж самнана.
2. Ямааны урт хялгасыг нь сэрмэж хайчилсны дараа самналтаа эхэлнэ.
3. Ноолуур нь хэвийн  $12 \pm 1\%$ -с хэтрээгүй амь чийгтэй байна.
4. Хаг, хогт хольцын хэмжээ ноолуурын нийт жингийн  $10\%$ -с хэтрээгүй байна /малын хоргол баас, будаг, үнс шороо гэх мэт гаднын элдэв хольцгүй/
5. Ноолуурын үндсэн /цайвар болон бараан/ өнгийг хооронд нь хольж ууталж болохгүй.
6. Малчдын авчирсан ууттай ноолуурыг задалж чанарын  $100\%$  шалгалт хийж авна.
7. Чийгтэй ноолуурыг ууталж хэрхэвч болохгүйг анхаарах

### **Нэг цэгт малчдын самнаж бэлтгэсэн ноолуур хүлээн авах дараалал болон чанарын шаардлага**

- Ноолуур хүлээн авах нэг цэгийг сумын төвд тусгайлан бэлтгэсэн агуулах байранд ажиллуулна.
- Ноолуур хүлээн авах хугацааг малчидтай холбогдон мэдээлэл авч ямаа самналт 50 гаруй хувьтай болсон үеэр сумын төвд хүлээн авна. Үргэлжлэх хугацаа 7 хоногт багтаахаар зохицуулна.
- Ямаа самналтаас өмнө өгөгдсөн заавар зөвлөгөөний дагуу бэлтгэсэн чанартай ноолуурыг мэргэжлийн чанар шалгагч нар шалгаж хүлээн авч тэнцсэн тохиолдолд мөнгийг шууд дансанд нь хийнэ.

- Чанарын шаардлагад тэнцэж хүлээн авсан ноолуурын 1 кг тутамд 2000 төгрөгийн урамшууллыг нэмж олгоно.

### ТХХМТ-н хүрээнд нэг цэгийн үйл ажиллагаанд оролцогчид

	Оролцогчид	Гүйцэтгэх үүрэг/оролцоо	Хүртэх ашиг
1	Бэлчээрийн гэрээ байгуулсан хоршооны гишүүн малчид	Малчдын бүлгийн хэмжээнд тухайн жилд нийт бэлтгэх, нэг цэгээр борлуулах ноолуурын хэмжээг урьдчилан гаргах Ноолуурыг стандартын дагуу бэлтгэж, нэг цэгээр хоршоогоор дамжуулан борлуулах	Тогтвортой ноолуур бэлтгэх мэдлэг чадвар, зориулалтын материал хэрэгсэлтэй болно Чанартай ноолуур бэлтгэж урамшуулалтай үнээр хоршоонд нийлүүлнэ. Хоршооноос үнийн зөрүү ноогдол ашиг авч орлого нэмэгдэнэ
2	ХАА-н Хоршоо	Нэг цэгийг ажиллуулах, гишүүн малчдын оролцоог хангах, нэг цэгт анхан шатны ангилалт хийх, худалдан авагчтай чанарын урамшуулалтай гэрээ байгуулах, ноолуурын үнийг хоршооны дансаар дамжуулан малчдад олгох, ноогдол ашиг хуваарилах зэрэг зохион байгуулалтын ажлыг хийх	Хоршооны эрхлэх үйл ажиллагаа нэмэгдэж орлого нэмэгдэнэ Үйл ажиллагаа жигдэрснээр хоршоонд итгэх малчдын хандлага оролцоо сайжирна. Боловсруулах үйлдвэртэй гэрээ байгуулан ажилласнаар байнгын түнштэй болно
3	Боловсруулах үйлдвэр буюу ноолуур худалдан авагчид	Малчдыг ноолуур бэлтгэлийн сургалт, зориулалтын хэрэгслээр хангах Нэг цэгээс гарал үүсэл тодорхой, стандартын шаардлага хангасан ноолуурыг чанарын урамшуулалтай үнээр орон нутагт худалдан авах	Гарал үүсэл нь тодорхой ноолуурыг нэг цэгт бөөгнүүлж, анхан шатны ангилалт хийсэн стандартын дагуу бэлтгэсэн ноолуур авснаар тээвэр, үйлдвэрлэлийн анхан шатны зардал хэмнэнэ Байнгын бэлтгэн нийлүүлэгчтэй болно

4	Сумын ХААТ, МЭТ-ийн мэргэжилтэн	Ноолуур бэлтгэл, самнах тээвэрлэх, жинлэх зэргийг нэг цэгт хянаж баталгаажуулна	Зах зээлд эрүүл, гарал үүсэл тодорхой мал нийлүүлж хүнсний аюулгүй байдал дээшилнэ
5	МЭҮН	Бэлтгэсэн ноолуурт нэг цэгт гарал үүслийн гэрчилгээг олгоно	Зах зээлд нийлүүлж байгаа ноолуурын гарал үүсэл, бэлтгэлийн чанарт тавих хяналт сайжирна  Гэрчилгээ олгохыг хөнгөвчилж зардал хэмнэнэ



Ноолуурын үйлдвэрийн  
мэргэжилтнүүд малчны  
хотонд тогтвортой  
ноолуур бэлтгэлийн  
сургалт хийж байгаа нь



Малчдыг зориулалтын  
уут, сам, дэвсгэрээр  
хангав.



Стандартын дагуу  
самнасан ноолуур



Бэлтгэсэн ноолуураа  
нэг цэгт зориулалтын  
шуудайд савлан авчирч  
байгаа нь



Нэг цэгт анхан шатны  
ангилалт хийж  
байгаа нь



Зориулалтын шуудайд  
савлан үйлдвэр лүү ачих

Малчин таны гараас чанартай түүхий эд гарах нь танд болон үйлдвэрт нэмүү ашиг бий болгож, бүтээгдэхүүний чанар, гадаад, дотоод зах зээлийн

чанарын шаардлагад нийцсэн брэнд бүтээгдэхүүн хийхэд таны оруулж байгаа хувь нэмэр юм.

#### **4.6 ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН 60.2.8-Д ЗААСАН ЧИГЛЭЛ НЭГ БҮРЭЭР СУМЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААНУУДЫН САНАЛ**

Аль чиглэлээр ямар үйл ажиллагааг малын тоо толгойн албан татварын орлогоор санхүүжүүлж болохыг ОНХС-ийн журамд тодорхой заагаагүйгээс болж сумаас санхүүжилт гаргах, хэрэгжилтэд хяналт тавихад бэрхшээлтэй байна. Иймд хамгийн үр дүнтэй, хэрэгжих боломжтой байдлаар загвар үйл ажиллагааны доорх саналыг дэвшүүлж байна.

<b>Үндсэн чиглэл</b>	<b>Загвар</b>
1. Бэлчээрийн менежментийг сайжруулах	Малын тоог бэлчээрийн даацад тохируулах бэлчээр ашиглалтын гэрээ байгуулах Бэлчээрийн ургац, даацыг жил бүр тогтоож, бэлчээр ашиглалтын гэрээ байгуулсан малчдын бүлгийн гэрээний хэрэгжилтийг дүгнэх Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх үүднээс малаа борлуулахад нь малчдад дэмжлэг үзүүлэх, урамшуулах Отор нөөц нутаг гаргаж, ашиглалтыг зохицуулах Бэлчээрийг сэлгэх, амраах, өнжөөх ажлыг төлөвлөж хэрэгжүүлэх
2. Бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх	Гүний худаг гаргах Гүний худаг засварлах Гар худаг гаргах Гар худаг засах Хөв, цөөрөм байгуулах Булаг шандын эх хаших хамгаалах Малын тэжээлийн усалгаатай тариалан эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, тоног төхөөрөмж, суваг шуудуу гэх мэт
3. Малын эрүүл мэндийг хамгаалах	Халдварт, шимэгч хорхойн өвчний үед хашаа хороо, саравч, байр, төлийн пүнз, тээврийн хэрэгсэл, ажлын тусгай хувцас, голомт гарсан бэлчээр усны цэгийг халдваргүйжүүлэх ажлыг гэрээний үндсэн дээр МЭҮН-ээр гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр Бэлчээр дэх үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх, халдваргүйжүүлэх тээврийн хэрэгслийн түлшний зардал



	Тухайн орон нутагт түгээмэл гарч хохирол учруулдаг халдваргүй өвчин, төрөл бүрийн хордлогын оношилгоо, эмчилгээг МЭҮН-ээр гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр
4. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	Халдвар (шүлхий, мялзан, цэцэг зэрэг гоц халдварт өвчнөөс бусад), зооноз халдварт (бруцеллёз, сүрьеэ, боом) өвчин оношилгоо, урьдчилан сэргийлэх арга хэмжээг МЭҮН-ээр гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр
5. Малын чанарыг сайжруулах	Малын ангилан ялгалтыг МЭҮН-ээр гүйцэтгүүлэх үйлчилгээний төлбөр Ангиллын үндсэн дээр тохируулан сонголт хийж, хээлтүүлгийн ажлыг зохион байгуулах ажлын үйлчилгээний төлбөр Сайн чанарын (цэвэр, эрлийз, шилмэл омгийн) бүх, хуц, ухна, хөлдөөсөн үр худалдан авах Сумын малыг төлөөлөх түүврээс малын ашиг шимийн үзүүлэлт /үхэр, хонь, ямааны амьдын жин, ямааны ноолуур, хонины ноос, тэмээний үнээний сүү/-ийг жил бүр хэмжиж, бүртгэл хөтлөх
6. Гамшгаас хамгаалах	Малын эрсдэлийн даатгалын шимтгэлийн зардал Өвөлжөө, хаваржааны хашаа, саравчийг хүчтэй салхи, шороон шуурганы нөлөөллөөс хамгаалах зорилгоор мод тарих Өвөлжөө, хаваржааны хашаа саравчийг засах
7. Хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх	Үүлэн нөлөөлж бороо оруулахад хандив оруулах
8. Малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх	Бууцны хөлд тариалах зориулалтаар тэжээлийн ургамлын үр худалдан авах зардал Нэмэгдэл тэжээл бэлтгэх (өөрөө бэлтгэх болон зах зээлээс худалдан авах) зардал
9. Байгаль орчныг хамгаалах	Булаг шандын эхийг хашиж хамгаалах Зэрлэг амьтанд өвс тэжээл тавьж өгөх Тарвага нутагшуулах Идэвхтэн байгаль хамгаалагчдын зардал
10. Хортон мэрэгчидтэй тэмцэх	Байгаль орчинд ээлтэй аргаар бэлчээрийн мэрэгч, шавжтай тэмцэх
11. Малчдад зориулсан сургалт, сурталчилгааны зардалд зарцуулна	Дээрх бүх чиглэлээр мэргэжлийн байгууллага, хувь хүнээс сургалт зөвлөгөө авах

# ТАВ. ЗАГВАР ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХАМТРАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ОРОЛЦОГЧИДТОЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

## 5.1 НОЛУУР БЭЛТГЭЛИЙН ЧИГЛЭЛЭЭР БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичиг

2023 оны .... -р сарын ..... № ..... Улаанбаатар хот

### 1. Хамтран ажиллагч талууд

Уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох, тогтвортой ноолуур бэлтгэлийг нэг цэгт төвлөрүүлэн анхан шатны ангилалт хийж худалдан борлуулах загвар үйл ажиллагааг ..... аймгийн ..... суманд хэрэгжүүлж, бусад сум хоршоо, үйлдвэрлэгчдэд дэлгэрүүлэхээр тохирч энэхүү санамж бичгийг үйлдэв.

#### Хамтран ажиллагч талууд:

- 1.1 Бодлого судлалын төв, төлөөлж, Тэргүүн доктор А.Энх-Амгалан
- 1.2 Монголын Ноос Ноолуурын Холбоо, Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг
- 1.3 ..... ХХК, захирал .....
- 1.4 ..... аймаг ..... сумын ..... хоршоо, дарга .....

### 2. Загвар үйл ажиллагааны зорилго

Загвар үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан байгалийн нөөцийг зохистой ашигладаг, чанар, бүтээмжид суурилсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангаж, малын тоог бус мал, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх сэтгэлгээг малчдад төлөвшүүлж, тэдний шийдвэр, зан үйл болгох доорх сонирхлын хөшүүргүүдийг нэвтрүүлэх юм . Үүнд:

- 2.1. Малын тоог цөөлж, малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэх боломжийг малчдад ойлгуулах нүүр тулсан сургалт

- 2.2. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлтэй сумын Засаг дарга, малчдын бүлгийн хооронд байгуулах бэлчээр ашиглалтын гэрээ /БАГ/
- 2.3. Малаа борлуулж, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/
- 2.4. Мал, ноолуурыг бөөгнүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт
- 2.5. Малыг бага насанд нь нядалгааны жинд хүргэн борлуулах зорилгоор хурга махлуулах
- 2.6. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг гоц халдварт өвчнөөс эрүүлийг гэрчилгээжүүлж, мал, бүтээгдэхүүний борлуулалт, үнийг өсгөх загвар
- 2.7. Төр, хувийн хэвшил, малчдын хөрөнгө оруулалтыг татах замаар төслийн явцад илрүүлэн хэрэгжүүлэх боломжтой бусад загвар үйл ажиллагаа

Дээрх загвар үйл ажиллагааг хэрэгжүүлснээр малчдын хамтын ажиллагааг дэмжин ноолуураа нэг цэгт цуглуулж чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах ажлыг зохион байгуулалтын хийнэ.

### **3. Ноолуурыг нэг цэгт төвлөрүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах Загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын гүйцэтгэх үүрэг**

#### **3.1. Бодлого судлалын төвийн гүйцэтгэх үүрэг**

- 3.1.1. Тогтвортой ноолуур бэлтгэх сургалтыг төсөлд хамрагдсан малчдад боловсруулах үйлдвэр , хоршоотой хамтран зохион байгуулах
- 3.1.2. Малчдын бүлгийн зах зээлд борлуулах ноолуурыг малчид, хоршоотой хамтран нэг цэгт төвлөрүүлж, гарал үүслийг үнэн зөв бүрдүүлэн худалдан авагчийн шаардлагад нийцсэн тогтвортой ноолуурыг бэлтгэн нийлүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх

- 3.1.3. Ноолуур борлуулсны орлого, түүнээс олсон ашгийг гишүүн малчдад хуваарилах, ноогдол ашгийг хоршооны зүгээс олгоход хяналт тавьж ажиллах
- 3.1.4. Нэг цэгээр ноолуур худалдан авах байршил, хугацаа, ноолуур бэлтгэлд тавигдах худалдан авагч үйлдвэрийн шаардлага зэрэг мэдээллийг малчид, хоршооны удирдлагад хүргэх, биелүүлэх ажлыг зохион байгуулах
- 3.1.5. Ноолуур бэлтгэлийн үед ямаа самнах, өнгө болон насаар нь ноолуурыг тусад нь ууталж савлах, хаягжуулах, гарал үүслийг баталгаажуулах, сумын төвд авчрах ажлыг холбогдох талуудтай хамтран зохион байгуулах
- 3.1.6. Ноолуур бэлтгэл, худалдан авалт, тээвэрлэлт, ангилан ялгалт, угаах, самнах, ээрэх, сүлжих зэрэг дамжлага бүр дээр хяналт тавих, зардал, үр өгөөжийн эдийн засгийн тооцоо хийх ажлыг оролцогч талуудтай хамтран зохион байгуулж, үр дүнг оролцогч талуудад мэдээлэх
- 3.1.7. Энэхүү санамж бичгийн 2.4-2.6-д заасан загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөг боловсруулж, АДАПТ төсөл, орон нутгийн ашиг хүртэгчдийн саналыг тусган төр-хувийн хэвшил, малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар хэрэгжүүлэх
- 3.1.8. Загвар үйл ажиллагааг суманд хэрэгжүүлэх, түүнийг цаашид тогтвортой үргэлжлүүлэх чадавхыг бий болгох сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.1.9. Загвар үйл ажиллагааны үр өгөөжийг сурталчлах замаар түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшил, малчдын зүгээс гаргуулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын үзэсгэлэнг тогтмол зохион байгуулах
- 3.1.10. Загвар үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх сургалт, сурталчилгааг 4 аймгийн бусад сумдад зохион байгуулах, хэрэгжилт үр дүнг аймаг, үндэсний болон олон улсын байгууллагуудад түгээх, сурталчлах

## **3.2. Монголын ноос ноолуурын холбооны гүйцэтгэх үүрэг**

- 3.2.1. АДАПТ төслийн зорилго, нэг цэгээр ноолуур борлуулах үйл ажиллагаа, түүний үр дүнг гишүүн компаниудад сурталчлах мэдээллээр хангах

- 3.2.2. Төсөл хэрэгжиж байгаа 4 аймгийн 8 сумын төсөлд хамрагдсан малчдын бэлтгэсэн ноолуурыг 3.3.1-3.3.7 заалтад заасан үүргийг биелүүлэх компаниудыг төсөлд санал болгож гэрээ байгуулахад хамтран ажиллах
- 3.2.3. Төслийн аймаг сумдаас ноолуур худалдан авах бусад компаниудын талаарх мэдээлэл, ноолуурыг хэдий хэмжээгээр, ямар үнээр хэзээ худалдан авах гэх мэт/ -ийн талаар БСТ, хоршоодод мэдээлэх
- 3.2.4. Төсөлтэй хамтран ажиллаж байгаа компаниудад холбооны зүгээс дэмжлэг үзүүлэх
- 3.2.5. Төслийн хүрээнд бэлтгэсэн ноолуурыг боловсруулах шатанд гарц, чанар, зардлын ялгааг тогтоох хөндлөнгийн баг байгуулан хамтран ажиллах (Үйлдвэрийн мэргэжилтнүүд, Бодлого судлалын төв, Монголын ноос ноолуурын холбоо, нэхмэлийн хүрээлэн, хөндлөнгийн мэргэжлийн хүний бүрэлдэхүүнтэй)

### **3.3. .... ХХК–ны гүйцэтгэх үүрэг**

- 3.3.1. 2024 оны ноолуур бэлтгэлийн улиралд ..... аймгийн .....сумын төсөлд хамрагдсан малчдын тогтвортой ноолуурыг суманд нь очиж худалдан авах
- 3.3.2. Ноолуур бэлтгэлийн өмнө сумдад хийх тогтвортой ноолуурын сургалтад компанийн мэргэжлийн хүмүүсийг оролцуулах, компанийн зүгээс ямар шаардлага хангасан ноолуурыг урамшуулалт үнээр авах талаар малчид хоршоонд таниулах
- 3.3.3. Сум тус бүрээс хамгийн багадаа 3 тонн тогтвортой ноолуурын шаардлага хангасан ноолуур худалдан авах
- 3.3.4. Малчдын бэлтгэсэн ноолуурыг тухайн үеийн зах зээлийн үнээр авч, тогтвортой ноолуурын шаардлага хангасан ноолуурын 1 кг тутамд 2000-с доошгүй төгрөгийн урамшуулал олгох
- 3.3.5. Ноолуур худалдан авч ачилт хийсэн тухайн өдрөө төлбөрийг хоршооны дансанд шилжүүлэх
- 3.3.6. Ямаа самнах, ноолуур худалдан авах, савлах, хадгалах, тээвэрлэх бүхий л үйл ажиллагаанд компанийн төлөөллийг оролцуулж, сум орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажиллах

3.3.7. Тогтвортой ноолуурын шаардлага хангасан ноолуурын үйлдвэрийн шат дамжлага бүрд оролцогч талуудтай хамтран хяналт тавьж, үр дүнг оролцогч талуудад мэдээлэх

#### **3.4. Хоршооны гүйцэтгэх үүрэг**

3.4.1. Бүх гишүүдийн хурлыг хийж төслөөр хэрэгжүүлэх ажлыг танилцуулж, төсөлд хамрагдсан малчдыг гишүүнээр элсүүлж хоршооны үйл ажиллагааг идэвхжүүлэх

3.4.2. Нэг цэгээр ноолуур бэлтгэх үйл ажиллагааг хоршооны гишүүдэд сурталчлан таниулах гишүүн өрхүүдийн оролцоог жигд хангах

3.4.3. Нэг цэгээр ноолуур борлуулах хугацаа, худалдан авах хэмжээ, чанарын шаардлага, худалдан авах үнийг гишүүдэд урьдчилан мэдээлэх

3.4.4. Нэг цэгт бэлтгэн нийлүүлэх ноолуурын хэмжээг гишүүн өрх бүрээр урьдчилан гаргах

3.4.5. Ноолуур худалдан авах байр, хадгалах агуулах, электрон жин, ажиллах хүн хүчийг хариуцах

3.4.6. Худалдан авагч хүсэлт гаргасан нөхцөлд тээвэрлэх автомашин, хүн хүчийг хариуцах

3.4.7. Ноолуур борлуулах хугацаанд нэг цэгээр борлуулсан ноолуурын төлбөрийн гүйлгээг тусдаа данс нээж төслийн ажилтны 2-р гарын үсэгтэйгээр гүйцэтгэх

3.4.8. Ноолуур борлуулсны үнээс орон нутгийн ханшаар тооцсон төлбөрийг ажлын 3 хоногийн дотор гишүүний дансанд шилжүүлэх

3.4.9. Ноолуурын чанарын нэмэгдэлд ноогдох хэсгээс ноолуур бэлтгэн нийлүүлэхтэй холбоотой хоршооны үйл ажиллагааны зардлыг хасаж хоршооны ашгийг тооцох

3.4.10. Хоршооны ашгийг гишүүдэд олгох үнийн зөрүү, ноогдол ашиг, гишүүдийн оролцоо хэлбэрээр хэзээ хэрхэн хуваарилах асуудлыг гишүүдтэй зөвшилцөж хоршооны дүрмийн дагуу шийдвэрлэх

#### **4. Бусад асуудлууд**

4.1. Энэхүү Санамж Бичгийг 2023 оны ... сарын ... өдөр үйлдэв. Хүчинтэй хугацаа 2024 оны 12 сар хүртэл

- 4.2. Талууд Санамж Бичигт туссан хийх ажлыг хамтран хэрэгжүүлэхдээ тухай бүр шаардлагатай нарийвчилсан нөхцөлийг харилцан тохиролцож тусгайлсан гэрээ хэлцэл байгуулна.
- 4.3. Туршилтын ажлын үр дүнг эзэмших, ашиглах, ашиг хүртэх, хүртээх асуудалд талууд адил тэгш эрхтэй байна.
- 4.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 4.5. Санамж Бичгийг Монгол улсын хуулийн дагуу байгуулж, талуудад 1 хувийг хадгалуулав.

Талууд энэ хамтран ажиллах санамж бичигт дурдсан зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн болно.

### САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

Бодлого Судлалын Төв	Гарын үсэг
Тэргүүн А.Энх-Амгалан	.....
Монголын Ноос Ноолуурын Холбоо	Гарын үсэг
Гүйцэтгэх захирал Д.Алтанцэцэг	.....
..... ХХК	Гарын үсэг
Захирал .....	.....
..... хоршоо	Гарын үсэг
Дарга .....	.....

## 5.2 ХАА-Н БИРЖТЭЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичиг

2023 оны 6-р сарын...

№

Улаанбаатар хот

### 1. Хамтран ажиллагч талууд

Уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох, малыг нэг цэгээр, хоршоогоор дамжуулан худалдан борлуулах загвар үйл ажиллагааг Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Дарви, Завхан аймгийн Алдархаан, Шилүүстэй, Дорнод аймгийн Чойбалсан, Баянтүмэн, Сүхбаатар аймгийн Халзан, Түвшинширээ сумдын хоршоодтой хамтран

хэрэгжүүлж, бусад сумдад дэлгэрүүлэхээр тохирч энэхүү санамж бичгийг үйлдэв.

#### **Хамтран ажиллагч талууд:**

- 1.1. Бодлого судлалын төв, төлөөлж, тэргүүн доктор А.Энх-Амгалан
- 1.2. ХАА-н бирж /цаашид бирж гэх/ ийг төлөөлж, ТӨХК-ны гүйцэтгэх захирал О.Нарандэлгэр

#### **2. Загвар үйл ажиллагааны зорилго**

Загвар үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан байгалийн нөөцийг зохистой ашигладаг, чанар, бүтээмжид суурилсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангаж, малын тоог бус мал, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх сэтгэлгээг малчдад төлөвшүүлж, тэдний шийдвэр, зан үйл болгох доорх сонирхлын хөшүүргүүдийг нэвтрүүлэх юм . Үүнд:

- 2.1. Малын тоог цөөлж, малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэх боломжийг малчдад ойлгуулах нүүр тулсан сургалт
- 2.2. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлтэй сумын Засаг дарга, малчдын бүлгийн хооронд байгуулах бэлчээр ашиглалтын гэрээ /БАГ/
- 2.3. Малаа борлуулж, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/
- 2.4. Мал, ноолуурыг бөөгнүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт
- 2.5. Малыг бага насанд нь нядалгааны жинд хүргэн борлуулах зорилгоор хурга махлуулах
- 2.6. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг гоц халдварт өвчнөөс эрүүлийг гэрчилгээжүүлж, мал, бүтээгдэхүүний борлуулалт, үнийг өсгөх загвар
- 2.7. Төр, хувийн хэвшил, малчдын хөрөнгө оруулалтыг татах замаар



төслийн явцад илрүүлэн хэрэгжүүлэх боломжтой бусад загвар үйл ажиллагаа

Дээрх загвар үйл ажиллагааг биржийн үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэхээр энэхүү санамж бичгийг байгуулав.

### **3. Загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын гүйцэтгэх үүрэг**

#### **3.1. Бодлого судлалын төвийн гүйцэтгэх үүрэг**

- 3.1.1. Энэхүү санамж бичгийн 2.1-2.7-д заасан загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөг боловсруулж, АДАПТ төсөл, орон нутгийн ашиг хүртэгчдийн саналыг тусган төр-хувийн хэвшил, малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар хэрэгжүүлэх
- 3.1.2. Загвар үйл ажиллагааг суманд хэрэгжүүлэх, түүнийг цаашид тогтвортой үргэлжлүүлэх чадавхыг бий болгох сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.1.3. Загвар үйл ажиллагааны үр өгөөжийг сурталчлах замаар түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшил, малчдын зүгээс гаргуулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын үзэсгэлэнг тогтмол зохион байгуулах
- 3.1.4. Загвар үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх сургалт, сурталчилгааг аймгийн сонгогдсон сумдад зохион байгуулах
- 3.1.5. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг холбогдох аймгийн, үндэсний болон олон улсын байгууллагуудад түгээх, сурталчлах
- 3.1.6. Хөдөө аж ахуйн бараа, түүхий эд арилжаалах цахим платформыг хөгжүүлж, нэвтрүүлэх талаар биржээс гаргасан саналыг тавьж шийдвэрлүүлэх талаар АДАПТ төсөлтэй хамтран ажиллах
- 3.1.7. Энэхүү санамж бичгийн 3.1.6-д заасан цахим платформыг хөгжүүлэхэд АДАПТ төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд түүнийг хөгжүүлэх, ХАА-н түүхий эдийг цахим платформоор дамжуулан борлуулах талаар биржтэй хамтран ажиллах
- 3.1.8. Энэхүү санамж бичгийн 3.1.6-д заасан цахим платформыг хөгжүүлэхэд АДАПТ төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудал шийдвэрлэгдээгүй тохиолдолд загвар сумдын ХАА-н түүхий эдийг биржийн одоогийн тогтолцоогоор дамжуулан зарлуулах, худалдан авагчтай холбох талаар биржтэй хамтран ажиллах

### **3.2. Биржийн гүйцэтгэх үүрэг**

- 3.2.1. Энэхүү санамж бичгийн 2.4-2.6-д заасан загвар үйл ажиллагааг нэр бүхий 8 суманд хэрэгжүүлэхэд БСТ-тэй бүх талаар хамтран ажиллах
- 3.2.2. Төслийн 8 суманд хамтран ажиллах хоршоодыг ХААБ-н гишүүн болоход нь дэмжлэг үзүүлж мэргэжил аргагүйн удирдлагаар хангах
- 3.2.3. Хамтран ажиллах хоршоодын нэг цэгээр бэлтгэж, чанар эрүүл мэнд, ногоон шалгуурыг хангасан мөшгөх боломжтой мал, малын гаралтай түүхий эдийн мэдээллийг өөрийн онлайн системд оруулж сурталчлах, шаардлагатай тохиолдолд агуулахын үйлчилгээ үйлчилгээ үзүүлэх
- 3.2.4. ХААБ-ээс санаачлан зохион байгуулах аливаа мал, малын гаралтай түүхий эдийн худалдаа, үзэсгэлэнд хамтран ажиллаж буй хоршоодыг оролцуулах
- 3.2.5. Чанар, эрүүл мэнд, ногоон шалгуурыг хангасан мөшгөх боломжтой мал, малын гаралтай түүхий эдийн худалдан авах сонирхолтой боловсруулах үйлдвэр, бусад талуудын эрэлт хэрэгцээний мэдээллийг өөрийн онлайн системд оруулж сурталчлах
- 3.2.6. Энэхүү санамж бичгийн 3.1.6-д заасан цахим платформыг хөгжүүлэхэд АДАПТ төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд мал бүртгэлийн болон мал эмнэлгийн мэдээллийн системтэй холбогдон ажиллах боломж бүхий Хөдөө аж ахуйн бараа, түүхий эд худалдаалах цахим платформын төслийг боловсруулах, хөгжүүлэх, нэвтрүүлэх талаар АДАПТ төсөл, Бодлого судлалын төвтэй хамтран ажиллах
- 3.2.7. Энэхүү санамж бичгийн 3.1.6-д заасан цахим платформыг хөгжүүлэхэд АДАПТ төслийн зүгээс санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудал шийдвэрлэгдээгүй тохиолдолд загвар сумдын ХАА-н түүхий эдийг биржийн одоогийн тогтолцоогоор дамжуулан зарлуулах, худалдан авагчтай холбох талаар Бодлого судлалын төвтэй хамтран ажиллах
- 3.2.8. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг биржийн арилжаанд оролцогчид болон холбогдох төрийн байгууллагад сурталчлан таниулах

#### 4. Бусад асуудлууд

- 4.1. Энэхүү Санамж Бичгийг 2023 оны .... сарын .... өдөр үйлдэв. Хүчинтэй хугацаа 2024 оны 12 сар хүртэл
- 4.2. Талууд Санамж Бичигт туссан хийх ажлыг хамтран хэрэгжүүлэхдээ тухай бүр шаардлагатай нарийвчилсан нөхцөлийг харилцан тохиролцож тусгайлсан гэрээ хэлцэл байгуулна.
- 4.3. Туршилтын ажлын үр дүнг эзэмших, ашиглах, ашиг хүртэх, хүртээх асуудалд талууд адил тэгш эрхтэй байна.
- 4.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 4.5. Санамж Бичгийг Монгол улсын хуулийн дагуу байгуулж, талуудад 1 хувийг хадгалуулав.

Талууд энэ хамтран ажиллах санамж бичигт дурдсан зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн болно.

#### САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

Бодлого Судлалын Төв	Гарын үсэг
Тэргүүн А.Энх-Амгалан	.....
ХАА-н Бирж, ТӨХК	Гарын үсэг
Гүйцэтгэх захирал О.Нарандэлгэр	.....

#### 5.3 МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАРТАЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох ажлын хүрээнд малын эрүүл мэндийг сайжруулах загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичиг

2023 оны 6-р сарын... № Улаанбаатар хот

##### 1. Хамтран ажиллагч талууд

Уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох загвар үйл ажиллагааны хүрээнд малын эрүүл мэндийг сайжруулах ажлыг Мал эмнэлгийн ерөнхий газартай хамтран хэрэгжүүлэхээр тохирч энэхүү санамж бичгийг үйлдэв.

Хамтран ажиллагч талууд:

- 1.1. Бодлого судлалын төв /БСТ/, төлөөлж, тэргүүн доктор А.Энх-Амгалан

1.2. Мал эмнэлгийн ерөнхий газар /МЭЕГ/, төлөөлж, дарга А.Нарантуяа

## **2. Загвар үйл ажиллагааны зорилго**

Загвар үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан байгалийн нөөцийг зохистой ашигладаг, чанар, бүтээмжид суурилсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангаж, малын тоог бус мал, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх сэтгэлгээг малчдад төлөвшүүлж, тэдний шийдвэр, зан үйл болгох доорх сонирхлын хөшүүргүүдийг нэвтрүүлэх юм . Үүнд:

- 2.1. Малын тоог цөөлж, малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэх боломжийг малчдад ойлгуулах нүүр тулсан сургалт
- 2.2. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлтэй сумын Засаг дарга, малчдын бүлгийн хооронд байгуулах бэлчээр ашиглалтын гэрээ /БАГ/
- 2.3. Малаа борлуулж, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр /ЭСҮТ/
- 2.4. Мал, ноолуурыг бөөгнүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт
- 2.5. Малыг бага насанд нь нядалгааны жинд хүргэн борлуулах зорилгоор хурга махлуулах
- 2.6. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг гоц халдварт өвчнөөс эрүүлийг гэрчилгээжүүлж, мал, бүтээгдэхүүний борлуулалт, үнийг өсгөх загвар
- 2.7. Малын эмийн зохистой хэрэглээг мөрдүүлж эхлэх загвар
- 2.8. Халдварт, шимэгч хорхойн өвчнөөс урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийх загвар
- 2.9. Төр, хувийн хэвшил, малчдын хөрөнгө оруулалтыг татах замаар төслийн явцад илрүүлэн хэрэгжүүлэх боломжтой бусад загвар үйл ажиллагаа

## **3. Загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын гүйцэтгэх үүрэг**

### **3.1. Бодлого судлалын төв /БСТ/-ийн гүйцэтгэх үүрэг**

- 3.1.1. Энэхүү санамж бичгийн 2.6-2.8-д заасан загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөг боловсруулж, АДАПТ төсөл,

орон нутгийн ашиг хүртэгчдийн саналыг тусган төр-хувийн хэвшил, малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар хэрэгжүүлэх

- 3.1.2. Загвар үйл ажиллагааг суманд хэрэгжүүлэх, түүнийг цаашид тогтвортой үргэлжлүүлэх чадавхыг бий болгох сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.1.3. Загвар үйл ажиллагааны үр өгөөжийг сурталчлах замаар түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшил, малчдын зүгээс гаргуулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын үзэсгэлэнг тогтмол зохион байгуулах
- 3.1.4. Малын эмийн хэрэглээнд хяналт тавьж, зохистой хэрэглээг төлөвшүүлэх зорилгоор МЭНС /МАНИС/-ийг өргөжүүлэн хөгжүүлэх талаарх МЭЭГ-н саналыг тавьж шийдвэрлүүлэх талаар АДАПТ төсөлтэй хамтран ажиллах
- 3.1.5. Загвар үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх сургалт, сурталчилгааг аймгийн сонгогдсон сумдад зохион байгуулах
- 3.1.6. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг холбогдох аймгийн, үндэсний болон олон улсын байгууллагуудад түгээх, сурталчлах

## **3.2. Мал эмнэлгийн ерөнхий газрын гүйцэтгэх үүрэг**

- 3.2.1. Энэхүү санамж бичгийн 2.6-2.8-д заасан загвар үйл ажиллагааг нэр бүхий 8 суманд хэрэгжүүлэхэд БСТ-тэй бүх талаар хамтран ажиллах
- 3.2.2. Төслийн 8 сум бүрд нэгээс доошгүй малчдын бүлгийг гэрээт бэлчээрийн түвшинд нь халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтооход төслийн 4 аймгийн МЭГ, 8 сумын МЭТ, МЭҮН-д үүрэг, чиглэл өгч хамтран ажиллах
- 3.2.3. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийг тогтоох ажилд аймгийн МЭГ-аас шинжээчийн баг томилж ажиллуулах, тус багт МЭГ-аас малын эмч ажиллуулах, МЭГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрээр малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийг тогтоож, батламж олгох ажилд дэмжлэг үзүүлж БСТ-тэй хамтран ажиллах
- 3.2.4. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийн

баримт бичигт заасан ажил, үүргийг аймгийн МЭГ, МЭТ, МЭҮН биелүүлж байгаад хяналт тавих, хамтран ажиллах

3.2.5. Малын хашаа, саравч, хороо, пүнз, өвсний хашаанд халдварт, шимэгч хорхойн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйтгэл хийх загвар боловсруулах туршилтын ажлыг төслийн 4 аймгийн 8 сумын зарим малчдын бүлгийн хэмжээнд сумын МЭТ-ийн болон МЭҮН-ийн малын эмч нараар хийлгэж, үр дүн гаргах ажлыг хэрэгжүүлэхэд БСТ-д дэмжлэг үзүүлэх

3.2.5. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг бүх аймгийн МЭГ, сумдын МЭТ, МЭҮН-д сурталчлах

#### **4. Бусад асуудлууд**

4.1. Энэхүү Санамж Бичгийг 2023 оны .... сарын .... өдөр үйлдэв. Хүчинтэй хугацаа 2024 оны 12 сар хүртэл

4.2. Талууд Санамж Бичигт туссан хийх ажлыг хамтран хэрэгжүүлэхдээ тухай бүр шаардлагатай нарийвчилсан нөхцөлийг харилцан тохиролцож тусгайлсан гэрээ хэлцэл байгуулж болно.

4.3. Туршилтын ажлын үр дүнг эзэмших, ашиглах, ашиг хүртэх, хүртээх асуудалд талууд адил тэгш эрхтэй байна.

4.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

4.15. Санамж Бичгийг Монгол улсын хуулийн дагуу байгуулж, талуудад 1 хувийг хадгалуулав.

Талууд энэ хамтран ажиллах санамж бичигт дурдсан зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн болно.

#### **САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН**

Бодлого Судлалын Төв	Гарын үсэг
Тэргүүн А.Энх-Амгалан	.....
Мал эмнэлгийн ерөнхий газар Дарга А.Нарантуяа	Гарын үсэг
	.....

## 5.4 АЙМГИЙН МАЛ ЭМНЭЛГИЙН ГАЗАРТАЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох  
загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж  
бичиг

2023 оны 6-р сарын...

№

Улаанбаатар хот

### 1. Хамтран ажиллагч талууд

Уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй  
холбох загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлын хүрээнд малын эрүүл  
мэндийг сайжруулах, эрүүл нутаг тогтоох чиглэлээр ..... аймгийн  
..... сумдад хамтран хэрэгжүүлэхээр тохирч энэхүү санамж  
бичгийг үйлдэв.

**Хамтран ажиллагч талууд:**

- 1.1. Бодлого судлалын төв, төлөөлж, тэргүүн доктор А.Энх-Амгалан
- 1.2. ....аймгийн Мал эмнэлгийн газар, төлөөлж, дарга .....

### 2. Загвар үйл ажиллагааны зорилго

Загвар үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа-2050” Монгол  
улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан байгалийн нөөцийг  
зохистой ашигладаг, чанар, бүтээмжид суурилсан бөгөөд уур амьсгалын  
өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангаж, малын тоог бус мал, бүтээгдэхүүний чанарыг  
эрхэмлэх сэтгэлгээг малчдад төлөвшүүлж, тэдний шийдвэр, зан үйл  
болгох доорх сонирхлын хөшүүргүүдийг нэвтрүүлэх юм. Үүнд:

- 2.1. Малын тоог цөөлж, малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэх  
боломжийг малчдад ойлгуулах нүүр тулсан сургалт
- 2.2. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлтэй сумын Засаг  
дарга, малчдын бүлгийн хооронд байгуулах бэлчээр ашиглалтын  
гэрээ /БАГ/
- 2.3. Малаа борлуулж, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ  
биелүүлэхэд нь урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр /  
ЭСҮТ/
- 2.4. Мал, ноолуурыг бөөгнүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж,

хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт

- 2.5. Малыг бага насанд нь нядалгааны жинд хүргэн борлуулах зорилгоор хурга махлуулах
- 2.6. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг гоц халдварт өвчнөөс эрүүлийг гэрчилгээжүүлж, мал, бүтээгдэхүүний борлуулалт, үнийг өсгөх загвар
- 2.7. Малын эмийн зохистой хэрэглээг мөрдүүлж эхлэх загвар
- 2.8. Халдварт, шимэгч хорхойн өвчнөөс урьдчилан сэргийлэх халдваргүйтгэл хийх загвар
- 2.9. Төр, хувийн хэвшил, малчдын хөрөнгө оруулалтыг татах замаар төслийн явцад илрүүлэн хэрэгжүүлэх боломжтой бусад загвар үйл ажиллагаа

### **3. Загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын гүйцэтгэх үүрэг**

#### **3.1. Бодлого судлалын төвийн гүйцэтгэх үүрэг**

- 3.1.1. Энэхүү санамж бичгийн 2.6-2.8-д заасан загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, төлөвлөгөөг боловсруулж, АДАПТ төсөл, орон нутгийн ашиг хүртэгчдийн саналыг тусган төр-хувийн хэвшил, малчдын түншлэл /ТХХМТ/-ийн зарчмаар хэрэгжүүлэх
- 3.1.2. Загвар үйл ажиллагааг суманд хэрэгжүүлэх, түүнийг цаашид тогтвортой үргэлжлүүлэх чадавхыг бий болгох сургалт, чадавхжуулах үйл ажиллагааг зохион байгуулах
- 3.1.3. Загвар үйл ажиллагааны үр өгөөжийг сурталчлах замаар түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшил, малчдын зүгээс гаргуулах зорилго бүхий хөрөнгө оруулалтын үзэсгэлэнг тогтмол зохион байгуулах
- 3.1.4. Загвар үйл ажиллагааг түгээн дэлгэрүүлэх сургалт, сурталчилгааг аймгийн сонгогдсон сумдад зохион байгуулах
- 3.1.5. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг холбогдох аймгийн, үндэсний болон олон улсын байгууллагуудад түгээх, сурталчлах

#### **3.2. Аймгийн мал эмнэлгийн газрын гүйцэтгэх үүрэг**

- 3.2.1. Энэхүү санамж бичгийн 2.6-2.8-д заасан загвар үйл ажиллагааг нэр бүхий 2 суманд хэрэгжүүлэхэд БСТ-тэй бүх талаар хамтран ажиллах



- 3.2.2. Төслийн 2 сум бүрд нэгээс доошгүй малчдын бүлгийг гэрээт бэлчээрийн түвшинд нь халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгаар тогтооход сумын МЭТ, МЭҮН-д үүрэг, чиглэл өгч хамтран ажиллах
- 3.2.3. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийг тогтоох ажилд аймгийн МЭГ-аас шинжээчийн багт малын эмч ажиллуулах, МЭГ-ын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрээр малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийг тогтоож, батламж олгох ажлыг БСТ-тэй хамтран гүйцэтгэх
- 3.2.4. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийн түвшинд халдварт өвчингүй, эрүүл, тайван нутгийн тогтвортой байдлыг хадгалах стратегийн баримт бичигт заасан ажил, үүргийг аймгийн мал эмнэлгийн газар биелүүлэх, энэ үүргээ хэрхэн биелүүлж байгаа талаар сумын МЭТ, МЭҮН-д хяналт тавих, хамтран ажиллах
- 3.2.5. Малын хашаа, саравч, хороо, пүнз, өвсний хашаанд халдварт, шимэгч хорхойн өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор халдваргүйтгэл хийх загвар боловсруулах туршилтын ажлыг Баянтүмэн, Чойбалсан сумдын МЭТ-ийн болон МЭҮН-ийн малын эмч нараар хийлгэж, үр дүн гаргах ажлыг БСТ-тэй хамтран зохион байгуулах
- 3.2.6. Загвар үйл ажиллагааны явц, үр дүнг аймгийн бүх сумдын МЭТ, МЭҮН-д сурталчлах

#### **4. Бусад асуудлууд**

- 4.1. Энэхүү Санамж Бичгийг 2023 оны .... сарын .... өдөр үйлдэв. Хүчинтэй хугацаа 2024 оны 12 сар хүртэл
- 4.2. Талууд Санамж Бичигт туссан хийх ажлыг хамтран хэрэгжүүлэхдээ тухай бүр шаардлагатай нарийвчилсан нөхцөлийг харилцан тохиролцож тусгайлсан гэрээ хэлцэл байгуулж болно.
- 4.3. Туршилтын ажлын үр дүнг эзэмших, ашиглах, ашиг хүртэх, хүртээх асуудалд талууд адил тэгш эрхтэй байна.
- 4.4. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр санамж бичигт нэмэлт өөрчлөлт оруулж болно.
- 4.5. Санамж Бичгийг Монгол улсын хуулийн дагуу байгуулж, талуудад 1 хувийг хадгалуулав.

Талууд энэ хамтран ажиллах санамж бичигт дурдсан зүйлүүдийг хүлээн зөвшөөрсөн болно.

### САНАМЖ БИЧИГ БАЙГУУЛСАН

Бодлого Судлалын Төв	Гарын үсэг
Тэргүүн А.Энх-Амгалан	.....
..... аймгийн мал эмнэлгийн газар	Гарын үсэг
Дарга .....	.....

### 5.5 АЙМГИЙН ХХААГ-ТАЙ БАЙГУУЛАХ САНАМЖ БИЧИГ

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэх талаар хамтран ажиллах санамж бичиг

2023 оны 6-р сарын... № Улаанбаатар хот

#### 1. Хамтран ажиллагч талууд

Уур амьсгалын өөрчлөлт /УАӨ/-д дасан зохицох, малчдыг зах зээлтэй холбох чиглэлээр загвар үйл ажиллагааг ..... аймгийн ..... суманд хамтран хэрэгжүүлэхээр тохирч энэхүү санамж бичгийг үйлдэв.

Хамтран ажиллагч талууд:

- 1.1. Бодлого судлалын төв, төлөөлж, тэргүүн доктор А.Энх-Амгалан
- 1.2. ....аймгийн ХХААГ-ыг төлөөлж дарга .....

#### 2. Загвар үйл ажиллагааны зорилго

Загвар үйл ажиллагааны зорилго нь “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогод заасан байгалийн нөөцийг зохистой ашигладаг, чанар, бүтээмжид суурилсан бөгөөд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйн салбарыг хөгжүүлэх явдал юм.

Дээрх зорилтыг хангаж, малын тоог бус мал, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх сэтгэлгээг малчдад төлөвшүүлж, тэдний шийдвэр, зан үйл болгох доорх сонирхлын хөшүүргүүдийг нэвтрүүлэх юм . Үүнд:

- 2.1. Малын тоог цөөлж, малын ашиг шим, орлогыг нэмэгдүүлэх боломжийг малчдад ойлгуулах нүүр тулсан сургалт
- 2.2. Малын тоог бэлчээрийн даацад нийцүүлэх нөхцөлтэй сумын Засаг дарга, малчдын бүлгийн хооронд байгуулах бэлчээр ашиглалтын гэрээ /БАГ/

- 2.3. Малаа борлуулж, бэлчээр ашиглалтын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь урамшуулах экосистемийн үйлчилгээний төлбөр / ЭСҮТ/
- 2.4. Мал, ноолуурыг бөөгнүүлэн чанар, гарал үүслийг баталгаажуулж, хоршоогоор дамжуулан боловсруулах үйлдвэрт гэрээгээр борлуулах түүхий эд бэлтгэлийн нэг цэгийн зохион байгуулалт
- 2.5. Малыг өсвөр насанд нь нядалгааны жинд хүргэн борлуулах зорилгоор хурга махлуулах
- 2.6. Малчдын бүлгийн гэрээт бэлчээрийг гоц халдварт өвчнөөс эрүүлийг гэрчилгээжүүлж, мал, бүтээгдэхүүний борлуулалт, үнийг өсгөх загвар
- 2.7. Төр, хувийн хэвшил, малчдын хөрөнгө оруулалтыг татах замаар төслийн явцад илрүүлэн хэрэгжүүлэх боломжтой бусад загвар үйл ажиллагаа

### **3. Загвар үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын гүйцэтгэх үүрэг**

#### **3.1. Бодлого судлалын төвийн гүйцэтгэх үүрэг**

